

ЗАЛУУЧУУДЫН ХУУРАМЧ МЭДЭЭЛЭЛД ӨРТӨХ ЭМЗЭГ БАЙДАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгааны тайлан



Судалгааг гүйцэтгэсэн:

IRIM судалгааны хүрээлэн

Судалгааны баг

- Төслийн багийн ахлагч Ц. Батсугар
- Зохицуулагч, ахлах судлаач Г. Жаргалмаа
- Судлаач Б. Батхүү

Судалгааг дэмжсэн:

Европын Холбооны Team Europe Democracy (TED) санаачилга

Талархал

Энэхүү судалгааны мэдээлэл цуглуулалтад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан Төв аймгийн Залуус ТББ, Хөвсгөл аймгийн Насан туршийн боловсролын төв (НТБТ), мөн судалгаанд оролцсон нийт залуучууддаа талархал илэрхийлье. Та бүхний оролцоо, санал бодол нь судалгааны үр дүнг бодит нөхцөл байдалд тулгуурлан боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан болно.

Мэдэгдэл

Энэхүү судалгааг Европын Холбооны санхүүжилттэй Team Europe Democracy (TED) санаачилгын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэв. Тайланд тусгагдсан үзэл санаа, дүгнэлт, тайлбар нь зөвхөн судалгааг гүйцэтгэсэн судлаачдын багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Европын Холбоо болон EU-TED санаачилга, мөн IRIM судалгааны хүрээлэнгийн албан ёсны байр суурийг төлөөлөхгүй болно.

Судалгаатай холбоотой санал, хүсэлт

Судалгаатай холбоотой санал, хүсэлт, тодруулгыг дараах хаягаар ирүүлнэ үү:

Independent Research Institute of Mongolia (IRIM)

И-мэйл: contact@irim.mn

Эшлэл авах хэлбэр

IRIM судалгааны хүрээлэн. (2026). *Залуучуудын хуурамч мэдээлэлд өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлс*. Улаанбаатар.

Copyright

© 2026 IRIM.

Энэхүү тайлангийн агуулгыг эх сурвалжийг дурдсан тохиолдолд эш татан ашиглана уу.

Товчилсон үгсийн жагсаалт

TED	Team Europe Democracy
XMMБ	Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол
DVI	Залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын индекс (Disinformation Vulnerability Index)
UNESCO / ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага
ANOVA	Нэг хүчин зүйлт дисперсийн шинжилгээ

Агуулга

Товчилсон үгсийн жагсаалт.....	2
Агуулга.....	3
Хураангуй.....	4
Төслийн танилцуулга.....	6
1. Судалгааны хэрэгцээ шаардлага, үндэслэл	7
2. Арга зүй.....	8
2.1 Судалгааны зорилго, зорилт	8
2.2 Судалгааны дизайн.....	8
2.3 Хэмжилтийн хүрээ ба асуумжийн бүтэц.....	8
2.4 Судалгааны түүвэр, зорилтот бүлэг	10
2.5 Судалгааны хязгаарлагдмал тал.....	11
3. Судалгааны үр дүн	12
3.1. Залуучууд хуурамч мэдээлэлд хэр эмзэг өртөмтгий вэ?	12
3.2. Залуучууд хуурамч мэдээлэлд өртөхөд ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?	13
3.2.1 Хүн ам зүйн хүчин зүйлсийн нөлөө	14
3.2.2 Хэвлэл, мэдээллийн боловсролын үзүүлэх нөлөө.....	16
3.2.3 Танин мэдэхүй, сэтгэл зүйн хүчин зүйлсийн нөлөө	17
3.3. Бүлгийн мэдээллийн орон зай.....	28
4. Хэлэлцүүлэг	31
Зөвлөмж	34
Ашигласан материалын жагсаалт	37

Хураангуй

Энэхүү судалгааны хүрээнд хот, хөдөөгийн 16–25 насны нийт 400 залуучуудыг хамруулан хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын түвшнийг тодорхойлж, уг эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх зорилгоор шат дараалсан статистик шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэлээ.

Эхлээд, эмзэг байдлыг хэмжихдээ баримт бичгийн судалгааны үр дүнд үндэслэн сонгон авсан хэмжигдэхүүнүүдийг нэгтгэн Хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын индекс (Disinformation Vulnerability Index буюу цаашид DVI гэх)-ийг тооцсон. Индексийг 1–5 түвшнээр үнэлсэн бөгөөд 1 нь хамгийн эмзэг, 5 нь хамгийн тэсвэртэй түвшнийг илэрхийлнэ.

Үүний дараа хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг (1) хүн ам зүйн хүчин зүйлс, (2) хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол, (3) танин мэдэхүй, сэтгэл зүйн хүчин зүйлс, (4) бүлгийн мэдээллийн орон зай, зан үйлийн нөлөө гэсэн дөрвөн үндсэн бүлгээр авч үзэн шинжилсэн. Эдгээр хүчин зүйл тус бүр нь олон дэд үзүүлэлтээс бүрдэх бөгөөд дэд үзүүлэлт бүрийн DVI-д үзүүлэх нөлөөг тусад нь үнэлэхийн зэрэгцээ, тухайн хүчин зүйлийн хүрээнд нэгтгэн авч үзэхэд эмзэг байдлын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг мөн шинжилсэн. Ингэснээр хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг бүрдүүлж буй гол хүчин зүйлс болон тэдгээрийн харьцангуй нөлөөллийг олон түвшинд тодорхойлох боломж бүрдэх юм.

Судалгааны үр дүнгээр **залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын индекс (DVI) 2.58/5.00 буюу дундаж түвшинд гарав.** Үүнээс хуурамч мэдээллийг таних байдал харьцангуй сайн (2.85), үнэн мэдээлэлд итгэх байдал жигд биш (2.71), хуурамч мэдээллийг хуваалцах хандлага дундаж түвшинд (2.18) байна. DVI дундаж түвшинд байгааг эмзэг байдал бага гэж шууд тайлбарлах нь учир дутагдалтай. Учир нь DVI-ын түвшинд мэдээлэлд үл итгэх, эргэлзэх хандлагууд тодорхой нөлөөтэй байна. **Залуучуудын 51.5% нь бүх эсвэл зарим үнэн мэдээлэлд ч итгэхгүй байгаа нь мэдээллийн ерөнхий итгэлийн хямрал байгааг харуулж байв.**

Шинжилгээний үр дүнгээс харахад нас, хүйс, боловсрол зэрэг хүн ам зүйн хүчин зүйлс нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын индекс DVI-тэй статистикийн ач холбогдол бүхий шууд хамаарал үзүүлээгүй. Хэмжсэн бүх хүн ам зүйн үзүүлэлтүүдийг нэгтгэн авч үзэхэд DVI-ийн ердөө 4.8 хувийг тайлбарлаж байсан бол **танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлийн хүчин зүйлс нийлээд индексийн 27.9 хувийг тайлбарлаж байв.** Эдгээрээс танин мэдэхүйн хүчин зүйл ($\beta=.290$) хамгийн хүчтэй нөлөө үзүүлсэн бөгөөд итгэл үнэмшлийн ($\beta=.218$) болон сэтгэл хөдлөлийн ($\beta=.207$) хүчин зүйлс мөн статистикийн ач холбогдол бүхий нөлөөтэй байлаа.

Энэ нь **залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал нь хүн ам зүйн суурь шинжүүдээс илүүтэйгээр мэдээллийг хэрхэн хүлээн авч, боловсруулж, үнэлдэг танин мэдэхүйн механизм, итгэл үнэмшлийн хэв шинж, сэтгэл хөдлөлийн хариу үйлдэлтэй холбоотой болохыг харуулж байна.**

Нөгөө талаас, хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын дундаж түвшин харьцангуй өндөр буюу 3.88/5.00 байсан ч DVI-тай статистикийн ач холбогдол бүхий хамаарал ажиглагдаагүй. Хэдий боловсролын түвшин нь DVI-тай шууд хамааралгүй байсан ч хуурамч мэдээлэлд итгэх, үнэн мэдээлэлд үл итгэх, хуурамч мэдээлэл түгээх хандлага, түүнчлэн танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлийн хүчин зүйлстэй хүчтэй хамаарал үзүүлсэн. Энэ нь **боловсрол нь хуурамч мэдээлэлтэй харилцах бодит зан үйл, шийдвэр гаргалтад шууд бусаар нөлөөлж байгааг илтгэнэ.**

Түүнчлэн DVI болон хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол хооронд хамаарал ажиглагдаагүй нь оролцогчдын өөрсдийн үнэлсэн мэдээллийн боловсролын түвшин бодит чадвар, зан үйлийг бүрэн төлөөлж чадахгүй байх талтайг харуулж байна. Өөрөөр хэлбэл, мэдээллийн боловсролын талаарх “өөрийн үнэлгээ” өндөр байх нь заавал хуурамч мэдээллийг зөв таньж, үнэлэх чадвартай гэсэн үг биш юм.

Сегментчилсэн шинжилгээний үр дүнгээр танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлийн хүчин зүйлсийн нөлөө нас болон байршлаас хамааран ялгаатай байв. Байршлаар авч үзвэл **хотын орчинд сэтгэл хөдлөлийн хүчин зүйл хамгийн хүчтэй нөлөөлж байсан бол хөдөөгийн орчинд танин мэдэхүй болон итгэл үнэмшлийн хүчин зүйлсийн нөлөө давамгайлж байлаа.**

Насны бүлгээр авч үзэхэд 16–18 насныханд гурван хүчин зүйл зэрэгцэн нөлөөлж байсан бол 19–21 насныханд сэтгэл хөдлөлийн хүчин зүйлийн нөлөө хамгийн өндөр, 22–25 насныханд итгэл үнэмшлийн хүчин зүйлийн нөлөө давамгайлж байв. Энэ нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг бууруулах арга хэмжээ нь бүх залуучуудад ижил байдлаар бус, харин нас болон оршин суугаа орчны онцлогт нь нийцүүлэх шаардлагатайг харуулж байв.

Энэхүү судалгааны өөр нэг зорилт нь залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал DVI-д бүлгийн мэдээллийн орчин болон мэдээлэлтэй харилцах зан үйлийн нөлөө байгаа эсэхийг тодорхойлох явдал байв. Үүний хүрээнд бүлгийн мэдээллийн орон зай, мэдээллийн хэрэглээний зан үйлийн шинжүүдэд үндэслэн кластер шинжилгээ хийж, залуучуудыг идэвхгүй хүлээн авагч (35.2%), идэвхтэй эрэлхийлэгч (32.9%), тусгаарлагдсан хэрэглэгч (31.9%) гэсэн гурван бүлэгт ангилсан. Шинжилгээний үр дүнгээр эдгээр бүлгүүд нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг шууд тодорхойлогч хүчин зүйл гэхээсээ илүүтэйгээр эмзэг байдлын ялгаатай хэв шинж, онцлог бүхий шинжүүдийг харуулж байгаа үр дүн ажиглагдсан.

Нийт үр дүнгээс үзэхэд залуучуудын DVI нь хэд хэдэн түвшний хүчин зүйлсийн харилцан үйлчлэлээр тодорхойлогдож байна. Нэгдүгээрт, нас, хүйс, боловсрол зэрэг хүн ам зүйн хүчин зүйлс дангаараа хүчтэй нөлөө үзүүлээгүй ч нийлмэл байдлаар тодорхой түвшний эмзэг байдлыг бүрдүүлэх суурь нөхцөл болж байна. Хоёрдугаарт, хувь хүний мэдээллийг хүлээн авах, боловсруулах, үнэлэхтэй холбоотой танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлийн хүчин зүйлс нь DVI-д хамгийн хүчтэй нөлөө үзүүлж буй үндсэн хүчин зүйлс байна. Гуравдугаарт, бүлгийн мэдээллийн орчин, мэдээлэл хэрэглээний зан үйл нь хувь хүний эмзэг байдал хэрхэн илрэх, бэхжихэд нөлөөлөх нийгмийн түвшний хүчин зүйл болж байна.

Иймээс хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг бууруулах арга хэмжээ нь зөвхөн хувь хүний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэхээс гадна бүлгийн мэдээллийн орчин, мэдээлэл хэрэглээний хэв маягийг харгалзан үзэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, үр дүнтэй нөлөөллийн ажил нь нэг талаас мэдээллийг шүүн тунгаах, баталгаажуулах хувь хүний чадавхыг бэхжүүлэх, нөгөө талаас бүлгийн мэдээллийн зан үйл, харилцааны орчныг хуурамч мэдээлэлд илүү тэсвэртэй болгоход чиглэсэн **хоёр түвшний арга хэмжээг хослуулж** чадвал илүү өргөн хүрээнд залуучуудад хүрч, урт хугацаанд тогтвортой нөлөө үзүүлэх боломжтой байна.

Төслийн танилцуулга

IRIM судалгааны хүрээлэн нь Европын Холбооны ардчилал, хүний эрх, хууль дээдлэх ёс, иргэдийн оролцоог бэхжүүлэх зорилготой Team Europe Democracy (TED) санаачилгын дэмжлэгтэйгээр “Хуурамч мэдээлэлтэй тэмцэх замаар ардчилал, шударга ёсыг бэхжүүлэх нь” төслийг 2025 оны 6 сараас 2026 оны 6 сарын хооронд хэрэгжүүлж байна. Уг төсөл нь нотолгоонд суурилсан, олон нийтийн оролцоонд тулгуурласан аргачлалаар хуурамч мэдээлэлтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх, улмаар ардчилсан үнэт зүйлсийг хамгаалахад хувь нэмрээ оруулахыг зорьж байна. Төсөл нь дараах дөрвөн үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд энэхүү судалгааг төслийн 2 дахь шатны үйл ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэв:

- (1) Хуурамч мэдээллийн нөхцөл байдлын зураглалын судалгааг гүйцэтгэх;
- (2) Олон нийтийн мэдээлэлтэй харилцах зан үйл, хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа хийх;
- (3) Хуурамч мэдээлэлд эмзэг өртөмтгий бүлэгт чиглэсэн нөлөөллийн төслийн загвар боловсруулж, турших;
- (4) Төслийн үр дүн, сургамжийг бүс нутгийн бусад улс орнуудтай хуваалцах зэрэг ажлууд багтсан.

Төслийн эхний шатанд хэрэгжүүлсэн “Монгол Улс дахь хуурамч мэдээллийн зураглалын судалгаа” -ны үр дүнгээр Монгол Улсад эрүүл мэнд, нийгэм, улс төр, санхүүгийн залилан шинжтэй хуурамч мэдээлэл хамгийн түгээмэл тархаж буй нь тогтоогдсон. Мөн эдгээр төрлийн хуурамч мэдээлэлд өртөх эрсдэл өндөртэй бүлгүүдийн онцлогийг баримт бичгийн шинжилгээ болон экспертүүдтэй хийсэн чанарын судалгаанд үндэслэн тодорхойлсон бөгөөд насны хувьд залуу эсвэл эсрэгээр ахимаг насныхан, боловсрол болон орлогын түвшин харьцангуй бага, мэдээллийн болон цахим боловсрол сул байх зэрэг нийтлэг шинжүүд ажиглагдсан.

Энэхүү судалгааны үргэлжлэл болгон хуурамч мэдээлэлд өртөх эрсдэл өндөр байж болзошгүй зорилтот бүлгүүдээс залуучуудыг сонгон “Залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс” судалгааг 2026 оны 2–5 дугаар сарын хугацаанд Улаанбаатар хот, Хөвсгөл болон Төв аймгийн 16–25 насны 400 залуучуудыг хамруулан гүйцэтгэлээ.

Төслийн дараагийн шатанд эдгээр судалгааны үр дүнд үндэслэн хуурамч мэдээлэл, түүний сөрөг үр дагавартай тэмцэх чиглэлд авч хэрэгжүүлэх бодит зөвлөмжүүдийг боловсруулах, улмаар эдгээр зөвлөмжөөс богино хугацаанд хэрэгжүүлж болох зарим үйл ажиллагааг хамруулан “нөлөөллийн төслийн загвар”-ыг боловсруулж, туршин хэрэгжүүлэхээр зорьж байна. Энэ утгаараа энэхүү судалгаа нь хуурамч мэдээллийг сөрөх бодит интервенцийн төлөвлөлтийг боловсруулахад шууд чиглэж буйгаас гадна хуурамч мэдээллийн талаарх судалгааны мэдлэг, нотолгооны санг баяжуулж, олон нийтийн мэдээллийн тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээрх бодлого, төсөл хөтөлбөрийн хэлэлцүүлэгт ашиглагдах чухал баримт нотолгоо болно гэдэгт судалгааны баг итгэлтэй байна.

Зураглалын судалгааны тайлантай доорх QR кодыг уншуулан бүрэн эхээр нь танилцах боломжтой.



1. Судалгааны хэрэгцээ шаардлага, үндэслэл

Монгол Улсад хуурамч мэдээлэл нь сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж, нийгмийн түвшинд бодит эрсдэл, сөрөг үр дагавар үүсгэж буй асуудал болсон байна. Энэхүү судалгааны суурь болгон 2025 оны 12 сард гүйцэтгэсэн Монгол Улс дахь хуурамч мэдээллийн зураглалын судалгаагаар хуурамч мэдээлэл нь олон төрлийн эх сурвалж, сувгаар дамжин өргөн хүрээнд тархаж, зөвхөн тодорхой мэдээлэлд итгүүлэхээс гадна иргэдийн мэдээлэлд итгэх ерөнхий итгэлцлийг сулруулж, төөрөгдөл бий болгож, улмаар нийгмийн сэтгэлзүйн эмзэг байдлыг нэмэгдүүлж байгаа үр дүнгүүд гарсан (IRIM, 2025). Үүний зэрэгцээ, үндэсний хэмжээний санал асуулгаар иргэдийн 85.8 хувь нь хуурамч мэдээллийг томоохон асуудал гэж үзэж байгаа нь (IRI, 2024) энэхүү асуудал Монголын нийгэмд өргөн хүрээтэй, бодит нөлөөтэй байгааг харуулж байна.

Гэсэн хэдий ч Монгол Улсад хийгдсэн өмнөх судалгаанууд нь ихэвчлэн тодорхой сэдэв, тодорхой суваг эсвэл тусгай арга техникт төвлөрсөн шинжтэй байсан бөгөөд хуурамч мэдээллийн экосистемийг бүхэлд нь хамарсан, ялангуяа хувь хүний түвшинд мэдээллийг хэрхэн хүлээн авч, үнэлж, цааш түгээж байгаа зан үйлийн механизмыг системтэйгээр судалсан судалгаа хомс хэвээр байна. Зураглалын судалгаа нь хуурамч мэдээлэл “яаж”, мөн “яагаад” нэмэгдэх болсныг тодруулахыг зорьсон бол энэхүү судалгаагаар “юу” иргэдийг хуурамч мэдээлэлд өртөмтгий, эмзэг болгож байгааг тодруулахыг зорив.

Иймд энэ удаагийн судалгааны гол хэрэгцээ нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг тоон байдлаар хэмжих, түүнд нөлөөлж буй танин мэдэхүй, сэтгэлзүй болон зан үйлийн хүчин зүйлсийг тодорхойлох, мөн аль бүлгүүд илүү эмзэг байгааг нотолгоонд суурилан тогтоох явдал юм. Ийнхүү хуурамч мэдээлэл нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүй болон бүлгийн цогц механизмаар хэрхэн иргэдэд нөлөөлж байгааг тайлбарлан, хуурамч мэдээллийн нөлөөллийн механизмыг саармагжуулах боломжийг эрэлхийлж буйгаараа онцлог юм. Энэ нь зөвхөн асуудлыг тодорхойлохоос цаашилж, ямар төрлийн интервенц илүү үр дүнтэй байх, ямар зорилтот бүлэгт чиглэх, ямар сувгаар хүргэх зэрэг бодит шийдлийг төлөвлөхөд шаардлагатай суурь нотолгоог бүрдүүлэх ач холбогдолтой.

Тиймээс энэхүү судалгааны үндсэн зорилго нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг хэмжихээс гадна уг эмзэг байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийг илрүүлж, тэдгээрт суурилан дараагийн шатны интервенцийн загварыг нотолгоонд суурилан боловсруулахад оршино. Зураглалын судалгаа болон энэхүү судалгаа нь хуурамч мэдээллийн талаар уялдаатай, цогц ойлголтыг бий болгох, улмаар “ямар асуудал байна вэ?” гэсэн ойлголтоос “яагаад ийм байна вэ?” болон “цаашид юу хийх вэ?” гэсэн бодлогын түвшний шийдэл рүү чиглэсэн чухал баримт, мэдээллийг бүрдүүлнэ гэдэгт судалгааны багийн зүгээс итгэж байна.

2. Арга зүй

2.1 Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгаа нь залуучуудын хуурамч мэдээлэлд итгэх эмзэг байдлыг тодорхойлж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тайлбарлах зорилготой бөгөөд дараах үндсэн асуултуудад хариулахыг зорив. Үүнд:

- **Залуучууд хуурамч мэдээлэлд хэр эмзэг байна вэ?** Өмнөх зураглалын (mapping) судалгааны үр дүнд залуучууд мэдээллийн боловсрол дутмаг байх болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан хуурамч мэдээлэлд өртөмтгий бүлгүүдийн нэг болох нь тогтоогдсон. Иймд энэхүү судалгаагаар залуучуудын эмзэг байдлын түвшнийг тоон хэмжилтээр үнэлэхийг зорив.
- **Мэдээллийн боловсрол нь эмзэг байдалд хэрхэн нөлөөлж байна вэ?** Олон улсын судалгаанд хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол (media and information literacy) нь хуурамч мэдээлэлд тэсвэртэй байдлын чухал хүчин зүйл гэж үздэг. Энэ хүрээнд Монголын залуучуудын мэдээллийн боловсролын түвшин, түүнд нөлөөлөх нийгэм, хүн ам зүйн хүчин зүйлс, мөн эмзэг байдалтай уялдах хамаарлыг шинжилсэн.
- **Хувь хүний мэдээллийн зан үйл болон сэтгэл зүйн хүчин зүйлс ямар нөлөөтэй вэ?** Хүмүүс мэдээллийг хэрхэн хүлээн авч, боловсруулж, түгээж буй зан үйл нь хуурамч мэдээлэлд итгэх, түгээх шийдвэрт шууд нөлөөлдөг. Иймд танин мэдэхүй, итгэл үнэмшилд суурилсан шүүлт, болон сэтгэл хөдлөлийн нөлөөг хамруулан судалсан.
- **Залуучуудын мэдээллийн орон зайн онцлог ямар байна вэ?** Залуучуудын мэдээлэл хүлээн авах суваг, орчин (information spaces) болон тэдгээр нь эмзэг байдалтай хэрхэн уялдаж байгааг тодорхойлохыг зорив.

2.2 Судалгааны дизайн

Судалгаанд туршилтын даалгавар (experimental tasks), өөрийн үнэлгээ (self-report)-ний асуулгаас бүрдэх тоон судалгааны олон хэмжилтийн (multi-method) дизайн ашиглан хуурамч мэдээлэлд эмзэг байдлын түвшин (Disinformation Vulnerability Index/DVI)-г хэмжих, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тайлбарлахыг зорив. Энэ нь хуурамч мэдээллийн талаар оролцогчдын бодит зан үйл (behavior), болон тэдний ойлголт, хандлагыг (perception) зэрэг хэмжих боломж олгох замаар хэмжилтийн сул талыг бууруулна гэж үзэв. Тухайлбал, энэхүү хосолсон арга нь оролцогч өөрийгөө “зөв” харагдуулах хандлагаас үүдэх social desirability bias-ийг бууруулж, зөвхөн субъектив хариултад тулгуурлах үед үүсдэг хэмжилтийн алдааг багасгана. Мөн нэг ойлголтыг хоёр өөр аргаар хэмжиж, жинлэн нэгтгэснээр тухайн хэмжиж буй бүтцийг илүү үнэн зөв, найдвартай тусгах боломжийг нэмэгдүүлнэ.

2.3 Хэмжилтийн хүрээ ба асуумжийн бүтэц

Хуурамч мэдээллийн талаар хийгдсэн өмнөх судалгаануудын ажиглалтад үндэслэн залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал нь нийгэм-хүн ам зүйн хүчин зүйлс, хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын түвшин, танин мэдэхүй болон сэтгэл зүйн хүчин зүйлсээр тодорхойлогдох боломжтой гэж үзэн шинжилгээний хүрээг гаргасан.

Залуучуудын хуурамч мэдээллийн эмзэг байдлыг тодорхойлохдоо 5 худал, 5 үнэн мэдээлэл бүхий нийт 10 контентыг харуулан, хуурамч мэдээллийг танин ялгах, итгэх байдал, хуваалцах хандлагуудыг хэмжин нийлмэл индексээр тодорхойлов.

Дүрс 1. Судалгааны дизайн



Хувь хүний танин мэдэхүйн болон сэтгэл зүйн хүчин зүйлсийг хэмжихдээ баримт бичгийн судалгааны үр дүнд үндэслэн хувь хүний түвшинд хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалд хамгийн тогтвортой, давтагдан ажиглагддаг гурван үндсэн хүчин зүйлсийг тодорхойлсон. Үүнд: (1) танин мэдэхүйн чадвар (cognitive capacity), (2) итгэл үнэмшилд суурилсан мэдээлэл боловсруулах хандлага (motivated reasoning), (3) сэтгэл хөдлөлийн өдөөлт (emotional arousal) болно.

Танин мэдэхүй болон сэтгэл зүйн хүчин зүйлсийн дээрх бүх дэд индикаторуудыг туршилтын даалгавар (experimental tasks) болон өөрийн үнэлгээ (self-report) гэсэн хоёр төрлийн хэмжилтийн аргаар үнэлэв.

Мөн судалгаанд ашигласан мэдээллийн контентыг бодит орчинд тулгуурлан сонгосон. Ингэхдээ 2023.03–2025.03 хугацаанд Монголын баримт шалгах төвийн шалгасан нийт 921 мэдээллийн сан дээр үндэслэн хоёр үе шаттай шүүлт хийж 5 үнэн, 5 худал мэдээллийг эцэслэн сонгосон. Контентоос үүдэх хамаарал, алдааг буруулах зорилгоор, эдгээр сонгосон контентыг харагдах байдлын хувьд жигдлэн форматалсан. Эцэст нь эдгээр мэдээлэлд үндэслэн туршилтын даалгавруудыг боловсруулсан.

Туршилтын дизайн: Мэдээллийн сонголтоос үүдэх bias-ийг бууруулах зорилгоор оролцогч бүрд ялгаатай мэдээ харуулах, мөн үнэн/худал мэдээллийг тэнцвэртэй хуваарилах шийдлийг ашигласан.

Үүний тулд Latin Square rotation буюу оролцогч бүрд ялгаатай мэдээг санамсаргүй байдлаар сонгон харуулах шоо хаях аргыг ашигласан бөгөөд ингэснээр тухайн мэдээний онцлогоос үүдэх нөлөөг багасгах, хэмжилтийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. Мөн оролцогчдыг Control бүлэг (n=200), Treatment бүлэг (n=200) гэж хуваан, тодорхой туршилтын нөхцөлд ялгаатай мэдээлэл үзүүлж, харьцуулсан шинжилгээ хийх боломж бүрдүүлсэн.

Асуумжийн бүтэц: Судалгааны асуумжийг дараах үндсэн бүтэцтэйгээр боловсруулсан:

1. Хүн ам зүйн мэдээлэл
2. Хуурамч мэдээлэлд эмзэг байдлыг хэмжих хэсэг
3. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол (ХММБ) -г тодорхойлох хэсэг
4. Танин мэдэхүйн ба сэтгэл зүйн хүчин зүйлсийн хэсэг
 - Туршилтын даалгавар (Хяналтын болон туршилтын бүлгээр ялгаатай)
 - Өөрийн үнэлгээ (self-report)
5. Бүлгийн мэдээллийн орон зай (community information space)-г тодорхойлох хэсэг

2.4 Судалгааны түүвэр, зорилтот бүлэг

Судалгаанд 16–25 насны залуучуудыг зорилтот бүлгээр сонгосон. Өмнөх зураглалын судалгааны үр дүнгээс харахад нас нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалд нөлөөлөх чухал хүчин зүйл бөгөөд ялангуяа залуу насанд мэдээллийг шүүн тунгаах чадвар, анхаарал төвлөрөл, когнитив боловсруулалтын хэв шинж зэрэг нь бүрэн төлөвшөөгүй байх хандлагатай байгааг тогтоосон. Иймд энэхүү судалгааг:

- өндөр эрсдэлтэй бүлгийг нарийвчлан судлах,
- интервенцийн зорилтот бүлгийг тодорхойлох,
- танин мэдэхүй болон сэтгэл зүйн онцлогийг гүйцэтгэлд суурилан хэмжих зорилгоор залуучуудын бүлэгт төвлөрүүлэн хэрэгжүүлсэн.

Судалгаанд нийт 400 оролцогч хамрагдсан бөгөөд газарзүйн хувьд Улаанбаатар хотоос 200, Хөвсгөл болон Төв аймгаас нийт 200 оролцогчийг сонгон хамруулсан. Оролцогчдыг гурван насны бүлгээр тэнцвэртэй хамруулахыг зорьсон бөгөөд хүйсийн хувьд 54% нь эмэгтэй байв. Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл оролцогчдын 23% нь ажил эрхэлдэг, 67% нь оюутан, сурагчид байсан бол үлдсэн 10 орчим хувийг ажилгүй залуучуудын төлөөлөл бүрдүүлсэн байна.

Хүснэгт 1. Түүврийн задаргаа

	Улаанбаатар хот, 6 дүүрэг	Хөвсгөл аймаг	Төв аймаг	Нийт
Нас				
16-18	67	33	33	133
19-21	67	34	34	135
22-25	66	33	33	132
Хүйс				
Эрэгтэй	99	43	42	184
Эмэгтэй	101	55	60	216
Нийт түүвэр	200	100	100	400

Төв болон Хөвсгөл аймгуудыг сонгохдоо зорилтот насны залуучуудын хүн амын төвлөрөл, газарзүйн ялгаатай байдал, нийгэм-эдийн засгийн нөхцөлийг харгалзан зорилтот байдлаар сонгосон. Түүврийг бүрдүүлэхдээ нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг үзүүлэлтүүдийг аль болох тэнцвэртэй хамруулах зорилгоор квот түүврийн арга ашигласан.

2.5 Судалгааны хязгаарлагдмал тал

Энэхүү судалгаа нь залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал болон түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг туршилтын асуултууд, өөрийн үнэлгээ болон зан үйлийн хандлагад суурилан хэмжсэн хэдий ч дараах хязгаарлагдмал талуудтай.

- Судалгаанд хамрагдсан оролцогчид нь Улаанбаатар хот, Төв болон Хөвсгөл аймагт амьдардаг 16–25 насны залуучууд байсан бөгөөд зөвхөн тухайн бүлгийн онцлог зан үйл, хандлагыг илэрхийлэх тул үр дүнг Монгол Улсын нийт хүн амд шууд ерөнхийлөн тайлбарлах боломжгүй.
- Судалгаанд ашигласан хуурамч болон үнэн мэдээллийн жишээнүүдийг зөвхөн Монголын баримт шалгах төвийн нягталсан мэдээллүүд дундаас сонгож авсан тул тухайн мэдээллийн сангийн хамрах хүрээ, онцлогоос шалтгаалсан тодорхой хязгаарлалт байж болно. Иймээс өөр төрлийн мэдээллийн агуулга, платформ болон мэдээллийн орчинд оролцогчдын хариу үйлдэл ялгаатай байх боломжтой. Судалгаанд ашигласан контентуудыг контентоос үүдэх хамаарал, харагдах байдлын нөлөөг бууруулах зорилгоор жигд форматалсан боловч бодит цахим орчны алгоритм, сэтгэгдэл, дүрслэл болон түгээлтийн нөхцөлийг бүрэн сэргээн дуурайлгасан байдал хязгаарлагдмал байж болно.
- Судалгаа нь нэг хугацаанд хийгдсэн cross-sectional шинжтэй тул хувьсагчдын хоорондын хамаарлыг тодорхойлох боломжтой боловч шалтгаант холбоог бүрэн тайлбарлах боломжгүй.
- Туршилтад ашигласан мэдээнүүд, баримт шалгалтын агуулга болон анхаарал татах элементүүдийг сошиал медиагийн бодит орчны нөхцөлийг аль болох дуурайлган боловсруулсан. Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдын туршилтын орчин дахь хариу үйлдэл нь бодит амьдрал дээр мэдээлэлтэй харьцах үеийн зан үйл, шийдвэр гаргалтаас тодорхой хэмжээнд ялгаатай байх боломжтой.
- DVI индекс нь хуурамч мэдээлэлд өртөмтгий байдлыг хэмжих зорилготой нийлмэл индекс боловч хүний мэдээлэл боловсруулах зан үйлийн бүх хүчин зүйлийг бүрэн хамарч чадахгүй бөгөөд цаашид илүү өргөн хүрээний баталгаажуулалт шаардлагатай.

3. Судалгааны үр дүн

3.1. Залуучууд хуурамч мэдээлэлд хэр эмзэг өртөмтгий вэ?


Монгол Улс дахь хуурамч мэдээллийн зураглалын судалгааны үр дүнгээр “залуучууд” мэдээллийн боловсрол дутмаг байх, шүүмжлэлт сэтгэлгээ сул байх болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан хуурамч мэдээлэлд өртөмтгий бүлгүүдийн нэг болох нь тогтоогдсон (IRIM, 2025). Иймд энэхүү судалгаагаар залуучуудын эмзэг байдлын түвшнийг тоон хэмжилтээр хэмжих буюу хуурамч мэдээллийн эмзэг байдлын индекс (цаашид Disinformation Vulnerability Index/DVI гэх) тооцох оролдлогыг хийлээ.

Хуурамч мэдээллийн эмзэг байдлын индексийг тооцохдоо баримт шалгах төвийн шалгаж “үнэн” болон “худал” мэдээлэл болох нь баталгаажсан 5 худал, 5 үнэн мэдээлэл бүхий нийт 10 контентыг харуулан, хуурамч мэдээллийг танин ялгах, итгэх байдал, хуваалцах хандлагуудыг хэмжин нийлмэл индексийг тооцсон.

Үр дүнг авч үзэхэд, судалгаанд оролцсон залуусын хуурамч мэдээллийн эмзэг байдлын дундаж түвшин 2.58 (1-5 хүртэлх шкалаар хэмжихэд) буюу эмзэг байдал дундаж түвшинд байна (Дүрс 2). Тус бүрд нь авч үзвэл залуучуудын хувьд худал мэдээллийг таних байдал сайн (2.85), үнэн мэдээлэлд итгэх байдал жигд биш (2.71), хуурамч мэдээллийг хуваалцах зан үйл дунд түвшинд (2.18) байгаа нь хуурамч мэдээлэлд өртөх ерөнхий эмзэг байдлыг харьцангуй бууруулж байна.

Дүрс 2. Залуучуудын эмзэг байдлын индекс, 1-5 хүртэлх шкалаас

Хуурамч мэдээллийн эмзэг байдлын индексийн тархалт




*1-Эмзэг байдал бага, 5-Эмзэг байдал өндөр

Залуучуудын хуурамч мэдээллийг ялгаж таних байдал сайн буюу 75.3% нь бүх эсвэл зарим (2 хүртэлх) хуурамч мэдээллийг ялгаж таньж байна. Тодруулбал, залуучуудын 35.8% нь бүх 5 хуурамч мэдээлэлд итгээгүй (Дүрс 3). Хуурамч мэдээлэлд итгэх байдал дунджаар 1.47 буюу нийт хуурамч мэдээллийн 29.4%-д нь судалгаанд оролцогчид итгэж байгаа бол хуурамч мэдээлэлд үл итгэх хандлага ялимгүй өндөр буюу 1.68 буюу 33.6% нь бүх хуурамч мэдээлэлд үл итгэж байгаа нь эерэг хандлага юм. Гэвч 31.5% нь нэг ч хуурамч мэдээллийг таньж чадаагүй буюу хуурамч мэдээлэлд итгэсэн эсвэл эргэлзсэн хариу үйлдэл үзүүлжээ. Судалгааны энэ үзүүлэлтүүд нь хянаж шалгах боломжгүй төвөгтэй улс төрийн худал нарратив буюу зохиомжуудыг таних байдлыг илтгэхгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

Харин үнэн мэдээллийг таних байдал жигд биш байна. Залуучуудын 51.5% нь бүх эсвэл зарим (2 хүртэлх) үнэн мэдээлэлд итгээгүй. Хэдийгээр судалгаанд оролцсон залуучууд нийт үнэн мэдээллийн талд нь буюу 49.2% нь итгэж байгаа ч залуучуудын 62.5% нь дор хаяж нэг болон түүнээс олон үнэн мэдээлэлд үл итгэх эсвэл эргэлзэх хариу үйлдэл үзүүлж байна. Энэ нь ерөнхий мэдээлэлд итгэх итгэл буурч байгааг илэрхийлж болох талтай.

Дүрс 3. Залуучуудын үнэн болон хуурамч мэдээллийг ялган таних чадварын тархалт



Судалгааны үр дүнгээс харахад залуучууд хуурамч мэдээллийг таних чадварын хувьд харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Тухайлбал, судалгаанд ашигласан мэдээллийн агуулгуудын 41.4%-ийг зөв ялган таньж, хуурамч мэдээлэлд үл итгэж, үнэн мэдээлэлд итгэсэн байна. Энэ нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг бууруулж буй эерэг үзүүлэлт юм.

Гэсэн хэдий ч анхаарал хандуулах шаардлагатай хэд хэдэн эрсдэлтэй хандлага ажиглагдсан. Нэгдүгээрт, нийт үнэлгээний 27%-д нь оролцогчид мэдээллийн үнэн худлыг буруу дүгнэж, хуурамч мэдээлэлд итгэх эсвэл үнэн мэдээлэлд үл итгэх хариу өгсөн байна. Энэ нь **дөрвөн залуу тутмын нэг нь мэдээллийг буруу үнэлж байгааг харуулж байна.**

Хоёрдугаарт, нийт хариу үйлдлийн 31.6%-д залуучууд мэдээллийн үнэн худлыг тодорхойлж чадаагүй, эргэлзсэн байр суурь илэрхийлжээ. Эргэлзэх хандлага нь зарим талаар хуурамч мэдээлэлд шууд итгэхээс сэргийлдэг эерэг талтай. Тухайлбал, залуучуудын хуурамч мэдээлэлд эргэлзэх түвшин (37%) нь үнэн мэдээлэлд эргэлзэх түвшнээс (26.2%) өндөр байна. Гэсэн хэдий ч мэдээллийн үнэн эсэхийг тогтоож чадахгүй байх нь мэдээллийг үнэлэх, шийдвэр гаргах чадвар хангалтгүй байгааг илтгэнэ.

Өөрөөр хэлбэл, залуучуудын DVI харьцангуй бага байгаа нь зөвхөн хуурамч мэдээллийг таних чадвартай холбоотой биш, мөн мэдээлэлд шууд итгэхээс илүү эргэлзэж хандах хандлагатай тодорхой хэмжээгээр холбоотой байна.

3.2. Залуучууд хуурамч мэдээлэлд өртөхөд ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?

Судалгаанд хамрагдсан залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын түвшин (DVI) нь дараах дөрвөн ерөнхий хүчин зүйлээр тодорхойлогдож буй эсэхийг судалгаагаар шинжилсэн. Хүчин зүйл бүр нь түүнийг илэрхийлэх хэд хэдэн дэд хувьсагчаас бүрдэх бөгөөд шинжилгээний хүрээнд дэд хувьсагч тус бүр DVI-д хэрхэн нөлөөлж байгааг тусад нь шалгасан. Мөн олон хүчин зүйлийг хамтад нь авч үзэн аль хүчин зүйл илүү хүчтэй нөлөө үзүүлж байгааг тодорхойлж, эдгээр хүчин зүйлс нийлээд хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг хэр сайн тайлбарлаж байгааг регрессийн шинжилгээгээр үнэлсэн. Үүний үр дүнд залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалд ямар хүчин зүйлс илүү нөлөөлж байгааг тодорхойллоо.

- Хүн ам зүйн хүчин зүйлсийн нөлөө

- Мэдээллийн боловсролын нөлөө
- Хувь хүний танин мэдэхүй, сэтгэл зүйн хүчин зүйлсийн нөлөө
- Бүлгийн мэдээллийн орон зайн нөлөө

Хүчин зүйл тус бүрээр үр дүнг дараагийн хэсгүүдэд танилцууллаа.

3.2.1 Хүн ам зүйн хүчин зүйлсийн нөлөө

Хүн ам зүй болон нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд тус тусдаа хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалтай нөлөөгүй, харин хүчин зүйлүүдийг хамтад нь авч үзэхэд эмзэг байдлын түвшинд бага хэмжээнд нөлөөтэй байна. Тодруулбал, эдгээр хүчин зүйлс болон DVI хоорондын хамаарлыг шалгах зорилгоор хийсэн статистик шинжилгээний үр дүн (Хүснэгт 2)-д дээрх хувьсагчид нь залуучуудын эмзэг байдлын түвшнийг тайлбарлах гол хүчин зүйл болж чадаагүй. Өөрөөр хэлбэл, хүн ам зүйн суурь шинжүүд нь залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалд нь шууд нөлөөгүй байна.

Хүснэгт 2. Хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд ба хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын хамаарал

Хувьсагч	Бүлэг	n	Эмзэг байдал	SD	Статистик	p
Хүйс	Эрэгтэй	184	40.31	11.82	$t(398) = 1.39$	.164
	Эмэгтэй	216	38.83	9.29		
Нас	—	400	—	—	$r = -.017$	.742
Үндэс угсаа	Халх	350	39.61	10.53	$t(398) = 0.49$	.627
	Бусад	50	38.83	10.72		
Гэрлэлтийн байдал	Ганц бие	366	39.14	10.49	$F(2, 397) = 2.75$	.065
	Гэрлэсэн	27	43.89	10.62		
	Хамтран амьдрагч	7	41.90	10.38		
Шашин шүтлэг	Будда	95	37.81	9.53	$F(3, 396) = 1.78$	.150
	Бөө	59	41.81	9.64		
	Шүтлэггүй	231	39.62	11.08		
	Бусад	15	39.67	10.56		
Боловсролын түвшин	Боловсролгүй	3	44.44	10.05	$p = -.072$	.149
	Бага, суурь	25	41.67	9.03		
	Бүрэн дунд, ТМС	306	39.80	10.76		
	Дээд	66	37.15	9.84		
Хөдөлмөр эрхлэлт	Байнгын ажилтай	74	39.50	9.86	$F(3, 396) = 0.12$	.948
	Ажилгүй	35	40.52	9.87		
	Оюутан, сурагч	269	39.41	10.91		
	Бусад	22	39.24	9.70		
Өрхийн орлого	$\leq 900,000$	49	41.43	10.26	$p = -.056$	.260
	900,001–2,100,000	131	38.94	9.90		
	2,100,001–3,000,000	91	40.29	10.87		
	3,000,001–4,000,000	78	39.23	10.49		
	$\geq 4,000,001$	51	38.17	11.91		
Байршил	Улаанбаатар	200	39.62	11.08	$F(2, 397) = 0.70$	.497
	Аймгийн төв	81	38.35	8.81		
	Сумын төв	119	40.13	10.72		


Тэмдэглэл. SD = стандарт хазайлт. t болон F нь бүлгүүдийн ялгааг шалгасан статистик үзүүлэлт. Насны хувьд Pearson-ийн хамаарал, боловсролын түвшин болон өрхийн орлогын хувьд Spearman-ийн хамаарлын шинжилгээний үр дүнг үзүүлэв. Бүх шинжилгээнд $p < .05$ үед статистикийн ач холбогдолтой гэж үзсэн.

Хуурамч мэдээллийн эмзэг байдал бага болон эмзэг байдал өндөр бүлгүүдийн хоорондын ялгаа, дүр зургийг тодруулах зорилгоор эмзэг бүлгийн индекс хамгийн бага 25% болон хамгийн өндөр 25%-ийг сонгож, тэдний хүн амзүйн шинжүүдийг Дүрс 4-т харуулав. Үр дүнгээс харахад, нас, байршил, хөдөлмөр эрхлэлтийн хувьд хоёр бүлгийн хооронд томоохон ялгаа ажиглагдаагүй. Тухайлбал, хоёр бүлгийн дундаж нас бараг ижил, Улаанбаатарт амьдардаг оролцогчдын хувь хоёр бүлэгт адил, мөн оюутан/сурагчдын эзлэх хувь ойролцоо байна.

Харин боловсрол, орлого, хүйсийн хувьд тодорхой ялгаа ажиглагдав. Эмзэг байдал хамгийн өндөр бүлэгт боловсролын түвшин харьцангуй доогуур, өрхийн орлого багатай, эрэгтэй оролцогчдын хувь бага зэрэг өндөр байхад эмзэг байдал хамгийн багатай бүлэгт дээд боловсролтой, өрхийн орлого өндөртэй, эмэгтэй оролцогчдын хувь их байна. Гэвч эдгээр ялгаа нь шалтгаан-үр дагаврыг нотлохгүй, зөвхөн өндөр болон бага эмзэг бүлгийн бүтцийн ялгааг харуулж буй дүр зураг юм.

Дүрс 4. Хамгийн бага болон хамгийн өндөр эмзэг 25%-ийн хүн ам зүйн дүр зураг

■ Хамгийн бага эмзэг 25% ■ Хамгийн өндөр эмзэг 25%



Бага эмзэг бүлгийн онцлог

Дээд боловсрол (23.4%), өрхийн орлого өндөр (≥4M: 17.8%), эмэгтэй хувь их (50.5%)

Өндөр эмзэг бүлгийн онцлог

Бага боловсрол (бага+суурь: 8.8%), орлого бага (≤900k: 16.5%), эрэгтэй хувь их (60.4%)

Ялгаа ажиглагдаагүй

Дундаж нас, Байршил (УБ), Хөдөлмөр эрхлэлт (оюутан) — хоёр бүлэгт бараг ижил

Дээрх нийгэм-эдийн засаг, хүн амзүйн шинжүүд хуурамч мэдээллийн эмзэг байдалд нөлөөлж буй эсэхийг олон хувьсагчийн шугаман регрессийн шинжилгээгээр шинжлэхэд загвар бүхэлдээ статистикийн ач холбогдолтой байлаа ($F(9, 390) = 2.18, p = .023$). Өөрөөр хэлбэл, эдгээр шинжүүдийг хамтад нь авч үзэхэд хуурамч мэдээлэлд эмзэг байдалд тодорхой хэмжээний нөлөөтэй болох нь харагдаж байна. Гэвч энэ нөлөө нь маш бага ($R^2 = .048$) буюу залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын 4.8%-ийг л тайлбарлаж байна.

Эдгээр үр дүнгээс үзэхэд хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг зөвхөн нас, хүйс, орлого, байршил зэрэг хүн ам зүй болон нийгэм-эдийн засгийн суурь шинжээр тайлбарлах боломж хязгаарлагдмал байна. Боловсролын түвшин нэмэгдэх тусам эмзэг байдал бага зэрэг буурах хандлага ажиглагдсан ч хүн ам зүйн хүчин зүйлс эмзэг байдлын индексийг тайлбарлах үндсэн хүчин зүйл биш байна. Иймээс “тодорхой нэг хүн ам зүйн бүлэг л хуурамч мэдээлэлд илүү өртөмтгий” гэж дүгнэхээс илүүтэй, хуурамч

мэдээлэлд өртөх эрсдэл нь олон бүлэгт тархсан нийтлэг асуудал гэж үзэх нь зүйтэй байна. Энэ нь цаашид зөвхөн хүн ам зүйн бүлэгт суурилсан арга хэмжээнээс гадна мэдээллийг хүлээн авч, үнэлж, итгэдэг зан үйл, танин мэдэхүйн хүчин зүйлсийг хамтад нь авч үзэх шаардлагатайг харуулж байна.

3.2.2 Хэвлэл, мэдээллийн боловсролын үзүүлэх нөлөө

ЮНЕСКО-оос (2013) хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол (media and information literacy)-ийг “иргэдэд төрөл бүрийн хэрэгсэл ашиглан бүх хэлбэрийн мэдээлэл, медиа агуулгад нэвтрэх, түүнийг хайж олох, ойлгох, үнэлэх, ашиглах, шинээр бүтээх, бусадтай хуваалцах чадварыг олгодог цогц чадамж юм” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ тодорхойлолтын дагуу хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол (ХММБ)-той хүн гэж дараах үндсэн гурван бүрэлдэхүүн бүхий ур чадваруудыг эзэмшсэн хүнийг хэлнэ. Үүнд:

Бүрэлдэхүүн 1: Мэдээлэл олж авах (Access and Retrieval)

Бүрэлдэхүүн 2: Мэдээлэл ойлгох, үнэлэх (Understanding and Evaluation)

Бүрэлдэхүүн 3: Мэдээлэл бүтээх, ашиглах (Creation and Utilization)

Тус судалгаанд ЮНЕСКО-ийн дээрх хүрээг баримталж, судалгаанд оролцогчид өөрсдийн ХММБ-оо үнэлэх өөрийн үнэлгээ (self-assessment)-г боловсруулсан. Ингэхдээ ХММБ-тай холбоотой нийт 12 бодомжийг уншуулж, оролцогчдын боловсрол, ур чадварыг 1-5 хүртэлх оноогоор үнэлүүлсэн. Эдгээр бодомжуудыг зохиохдоо Moto, Ratanaolarn, Tuntiwongwanich, & Pimdee (2018), Jones-Jang, Mortensen, & Liu (2019), Karlina (2019) нарын асуумжаас судалгааны онцлог, нөхцөл байдалдаа тохируулан, өөрчилж ашигласан.

Судалгааны үр дүнгээс харахад залуучууд өөрсдийн ХММБ-ыг өндрөөр үнэлж байна. Тухайлбал, залуучууд өөрсдийн ХММБ-г дунджаар 3.88 оноогоор буюу “сайн” гэж үнэлсэн ба хайлтын систем ашиглан мэдээлэл олж авах чадвар (4.26) болон буруу мэдээлэл хуваалцсан тохиолдолд засаж залруулах чадвар (4.24)-уудаа хамгийн өндрөөр үнэлсэн байв. Харин эсрэгээр хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж байр сууриа илэрхийлэх, хэлэлцүүлэгт оролцох чадвараа хамгийн багаар (2.76) үнэлжээ (**Error! Reference source not found.**).

ХММБ-ын өөрийн үнэлгээ нь судалгаанд оролцогчийн нас, боловсролын түвшин, өрхийн орлого, байршилтай бага зэргийн хамааралтай байна. Нас ($r = .214$, $p < .001$), боловсролын түвшин ($p = .226$, $p < .001$), өрхийн орлого ($p = .118$, $p = .018$) нэмэгдэх тусам судалгаанд оролцогч өөрийн ХММБ-ыг илүү өндрөөр үнэлж байна.

Хүснэгт 3. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын өөрийн үнэлгээ, бодомж бүрээр (1-5 оноо). ХММБ-ийг үнэлсэн 12 бодомж тус бүрээрх оролцогчдын дундаж оноо


№	Бодомж*	Дундаж оноо
1	Олон төрлийн эх сурвалжаас мэдээлэл хайж, олж чаддаг	4.13
2	Хайлтын систем ашиглан мэдээлэл олж чаддаг	4.26
3	Нарийвчилсан хайлтын арга ашигладаг	3.92
4	Мэдээллээ хадгалж, дараа ашиглаж чаддаг	4.03
5	Мэдээллийн зорилго, мессежийг ойлгодог	4.13
6	Олон эх сурвалжаас мэдээлэл нэгтгэн дүгнэдэг	3.96
7	Эх сурвалжийн найдвартай байдлыг шинжилдэг	3.81
8	Итгэхээсээ өмнө хэн, хэзээ, хаанаас эхэлснийг шалгадаг	3.90
9	Мэдээллийг ёс зүйтэйгээр бүтээж, илэрхийлж чаддаг	3.73
10	Хэвлэл мэдээллийн байгууллагад байр сууриа илэрхийлж чаддаг	2.76
11	Хуваалцахдаа зохистой арга хэрэглэдэг	3.69
12	Буруу мэдээлэл хуваалцсанаа засаж залруулдаг	4.24
	Нийт	3.88

* Тайланд зориулж товчилсон хувилбар

Мөн байршлын хувьд ялгаа ажиглагдсан ($F(2,397)=3.20$, $p=.042$) буюу сумын төвд амьдарч буй залуучууд ($M=3.7$) өөрсдийн ХММБ-ыг Улаанбаатар ($M=3.9$) болон аймгийн төвийн ($M=4.0$) залуучуудаас багаар үнэлжээ.

ХММБ-ын үндсэн гурван бүрэлдэхүүнээр авч үзэхэд, мэдээлэл олж авах чадварын (1-4-р бодомж) дундаж 4.09, мэдээллийг ойлгох, үнэлэх чадварын (5-8-р бодомж) дундаж 3.95, харин мэдээлэл бүтээх, ашиглах чадварын (9-12-р бодомж) дундаж 3.61 байна (Дүрс 5). Өөрөөр хэлбэл, **оролцогчид мэдээлэл олж авах болон үнэлэх чадвараа харьцангуй өндөр үнэлсэн бол мэдээлэл бүтээх, идэвхтэй оролцохтой холбоотой чадваруудыг илүү доогуур үнэлсэн байна.**

Дүрс 5. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын өөрийн үнэлгээ, бүрэлдэхүүн хэсгүүдээр (1-5 оноо). ХММБ-ын бүрэлдэхүүн тус бүрийн дундаж оноо



Гэвч судалгаанд оролцсон залуучуудын ХММБ-ын түвшин нь тэдний хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалтай нь хамааралгүй байв. Залуучуудын ХММБ-ын түвшний үнэлгээ нь хуурамч мэдээллийн эмзэг байдлын индекст нөлөөлж буй эсэхийг шугаман регрессийн шинжилгээгээр шалгахад статистикийн ач холбогдолтой нөлөө илрээгүй ($F(1, 398) = 0.152$, $p = .697$, $R^2 = .000$). Өөрөөр хэлбэл, өөрийгөө мэдээлэлтэй сайн ажиллаж чадна гэж үнэлсэн оролцогчид хуурамч мэдээлэлд бага өртөнө, эсрэгээрээ мэдээлэлтэй муу ажилладаг гэж үнэлсэн оролцогчид хуурамч мэдээлэлд илүү өртөнө гэж дүгнэх боломжгүй байна.

ХММБ-ын гурван бүрэлдэхүүн хуурамч мэдээллийн эмзэг байдалд нөлөөлж буй эсэхийг регрессийн шинжилгээгээр шинжлэхэд дэд бүрэлдэхүүн бүр хамааралгүй байлаа. (бүрэлдэхүүн 1: $p = .135$; бүрэлдэхүүн 2: $p = .830$; бүрэлдэхүүн 3: $p = .155$).

Дээрхээс харахад залуучууд өөрсдийн ХММБ-ыг дунджаас дээш гэж үнэлж байгаа боловч энэ өөрийн үнэлгээ нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг тодорхойлохгүй байна. Өөрөөр хэлбэл оролцогчдын өөрийгөө үнэлсэн ХММБ-ын түвшин нь тэдний бодит чадварыг бүрэн илэрхийлэхгүй байгаа ба хүмүүс өөрсдийгөө мэдээлэлтэй сайн ажиллаж чадна гэж үнэлсэн ч бодит нөхцөлд мэдээллийг ялгах, үнэлэх чадвар нь өөр байж болзошгүй байна. Шинжилгээний үр дүн нь ХММБ боловсрол ХМЭБ-д нөлөөгүй гэсэн үг биш юм, харин ХММБ-ыг объектив хэмжилтийн аргууд ашиглан цаашид тодорхойлон үнэлэх шаардлагатайг харуулж байна.


3.2.3 Танин мэдэхүй, сэтгэл зүйн хүчин зүйлсийн нөлөө

Монголд хуурамч мэдээллийн чиглэлээр хийгдсэн хэд хэдэн судалгаанд иргэд олон нийт хуурамч мэдээллийг итгэж хүлээж авахад зөвхөн мэдээллийн орчин, хуурамч мэдээллийн хэв маяг, арга техник зэрэг гадаад хүчин зүйлсээс гадна хүлээн авагч хувь хүний өөрийн хувийн онцлог шинжүүд нөлөөтэй байж болох талаар дурдсан байдаг (IRIM, 2025; OptimalNMax, 2024). Олон улсад хийгдсэн судалгаануудыг авч үзэхэд ч мөн адил хувь хүний мэдээллийг боловсруулах танин мэдэхүйн онцлог, мэдээллийг хүлээж авах сэтгэл зүйн механизмууд нөлөөлдөг болох нь олон талаар судлагдсан байна (Bastick, 2021; Lewandowski, 2024; Wolters et al., 2021).

Баримт бичгийн судалгааны эдгээр үр дүнгүүдэд тулгуурлан хувь хүний түвшинд хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалд хамгийн тогтвортой, давтагдан ажиглагддаг дараах гурван хүчин зүйлсийг

тодорхойлон залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдалд нөлөөлж буй эсэхийг шинжилсэн. Үүнд: (1) танин мэдэхүйн чадвар (cognitive capacity), (2) итгэл үнэмшилд тулгуурлан мэдээлэл боловсруулах хандлага (motivated reasoning), (3) сэтгэл хөдлөлийн өдөөлт (emotional arousal) болно.

Дүрс 6. Танин мэдэхүй, сэтгэл зүйн хүчин зүйлсийн хүрээнд хэмжсэн дэд үзүүлэлтүүд



1. Танин мэдэхүйн хүчин зүйлс буюу мэдээллийг боловсруулах чадвар. Танин мэдэхүйн хүчин зүйлс нь хүн мэдээллийг хэр гүнзгий, аналитик байдлаар боловсруулж чадаж байгаа эсэхийг тодорхойлдог. Судалгаануудын үр дүнгээс харахад хүмүүс мэдээллийг үргэлж шүүн тунгааж бус, харин ихэвчлэн хурдан, автомат (System 1) горимоор хүлээн авч, үнэн зөвийг нягтлахгүйгээр шийдвэр гаргах хандлагатай байдаг. Иймээс энэхүү судалгаанд танин мэдэхүйн хүчин зүйлийг төлөөлөх дэд индикаторуудыг (1) мэдээллийг анхааралгүй хүлээн авах байдал, (2) мэдээллийг давтамжаар үнэлэх хандлага, (3) эх сурвалжид итгэн эргэлзэлгүйгээр үнэн гэж хүлээж авах хандлага гэсэн гурван үзүүлэлтээр тодорхойлж хэмжив.

2. Итгэл үнэмшилд суурилсан мэдээлэл боловсруулах хандлага (Motivated reasoning). Хүмүүс мэдээллийг үнэн эсэхээр нь бус, харин өөрийн итгэл үнэмшил, үнэт зүйл, бүлгийн байр суурьтай нийцэж байгаа эсэхээр үнэлэх хандлагатай байдаг (Pennycook & G Rand, 2021). Судалгаанд үүнийг хамгийн нийтлэг төлөөлдөг дараах дэд индикаторууд болох (1) итгэл үнэмшилтэй зөрчилдөх мэдээлэлд хариулах байдал, (2) бусдын байр суурийг дагах, (3) эх сурвалжид шүүлтүүргүй итгэх, (4) залруулгыг хүлээн авахаас татгалзах байдал гэсэн дөрвөн үзүүлэлтийн хүрээнд тодорхойлов.

3. Сэтгэл хөдлөлийн нөлөө (Emotional arousal). Айдас, уур, жигшил, түгшүүр зэрэг өндөр өдөөлттэй сэтгэл хөдлөлүүд нь мэдээлэл боловсруулах үйл явцыг ихээхэн өөрчилдөг (Lewandowski, 2024; Wolters et al., 2021). Ялангуяа, хурдан дүгнэлт хийх (heuristic processing), баримт нягтлах хугацаа багасах, ёс суртахууны уур хилэнд суурилсан контентыг түгээх зэрэг зан үйл нэмэгддэг. Мөн moral-emotional framing бүхий мэдээлэл нь илүү итгэл төрүүлэх, илүү хурдан түгээх, баримт шалгах хэрэгцээг бууруулах хандлагатай байдаг байна. Судалгаанд (1) сэтгэл хөдлөлийн нөлөөг өндөр өдөөлттэй мэдээг хүлээн авах байдал (DISA, 2025), (2) шударга бус, ёс суртахууны хүрээнд хүлээж авах байдал (Pennycook & G Rand, 2021) гэсэн хоёр үзүүлэлтээр сэтгэл хөдлөлийн нөлөөг үнэлэв.

Судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл залуучуудын хуурамч мэдээлэлд өртөмтгий байдал нь үндсэндээ танин мэдэхүй, итгэл үнэмшилд суурилсан шүүлт, болон сэтгэл хөдлөлийн өдөөлт гэсэн гурван хүчин зүйлийн нийлмэл нөлөөгөөр тодорхойлогдож байна. Эдгээр хүчин зүйлс нь хамтдаа DVI-ийн 27.9%-ийг тайлбарлаж байгаа нь залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын тодорхой хэсэг нь мэдээллийг хэрхэн хүлээн авч, боловсруулж, сэтгэл хөдлөлөөр хариу үйлдэл үзүүлдэгтэй холбоотой байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, эмзэг байдалд нөлөөлж буй бүх

шалтгааныг бүрэн тайлбарлаж чадахгүй ч хамгийн нөлөөтэй хүчин зүйлсийн нэг хэсгийг эдгээр үзүүлэлтүүд тодорхойлж байна гэсэн үг юм.

Хүснэгт 4-д үзүүлсэн олон хувьсагчийн регрессийн үр дүнгээс харахад **танин мэдэхүйн хүчин зүйл хамгийн хүчтэй нөлөөтэй ($\beta = 0.290$), дараа нь итгэл үнэмшилдээ суурилах хандлага ($\beta = 0.218$), сэтгэл хөдлөлийн нөлөө ($\beta = 0.207$) тус тус орж байна.** Эдгээр бүх хүчин зүйлс статистикийн ач холбогдолтой ($p < .001$) гарсан бөгөөд VIF буюу дисперсийн инфляцийн хүчин зүйл 1.1–1.3 хооронд байгаа нь хувьсагчид хоорондоо хэт давхцалгүй, загварын үр дүн найдвартай байгааг харуулж байна. Энэ нь мэдээллийг шүүн боловсруулах чадвар суурь нөлөө үзүүлдэг ч хүмүүс мэдээллийг үргэлж логигоор үнэлдэггүй, харин өөрийн итгэл үнэмшилд нийцүүлэн тайлбарлах болон сэтгэл хөдлөлд автах хандлага давхар үйлчилдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, хуурамч мэдээлэлд өртөмтгий байдал нь зөвхөн танин мэдэхүйгээр бус, харин танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөл гэсэн гурван механизмын цогцолбор дээр бүрэлдэж байна. Мөн эдгээр хүчин зүйлс хамтдаа DVI-ийн 27.9%-ийг тайлбарлаж байгаа нь залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын тодорхой хэсэг нь мэдээллийг хэрхэн хүлээн авч, боловсруулж, сэтгэл хөдлөлөөр хариу үйлдэл үзүүлдэгтэй холбоотой болохыг харуулж байна.

Хүснэгт 4. DVI-д нөлөөлөх хүчин зүйлсийн олон хувьсагчийн регрессийн шинжилгээ

Үзүүлэлт	B	Std. Error	β (Standardized)	t	p-value	95% CI (Lower–Upper)	VIF
Cognitive	0.379	0.059	0.290	6.441	<0.001	0.263 – 0.495	1.113
Motivated reasoning	0.224	0.050	0.218	4.488	<0.001	0.126 – 0.323	1.299
Emotional arousal	0.156	0.036	0.207	4.343	<0.001	0.085 – 0.227	1.250
Constant	2.860	3.077	–	0.930	0.353	-3.188 – 8.909	–

Эдгээр хүчин зүйлсийн нөлөө нь орчны ялгаанаас хамааран (хот, хөдөө) өөр өөрөөр илэрч байна.

Хүснэгт 5-т харуулсан үр дүнгээс харахад хотын орчинд загварын тайлбарлах чадвар өндөр ($R^2 = 0.388$) бөгөөд сэтгэл хөдлөлийн хүчин зүйл хамгийн хүчтэй нөлөө үзүүлж ($\beta = 0.334$), сэтгэл хөдлөлд суурилсан контент залуучуудын эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд гол үүрэгтэй байна. Харин хөдөөгийн орчинд загварын тайлбарлах чадвар харьцангуй бага ($R^2 = 0.190$) бөгөөд emotional хүчин зүйл статистикийн ач холбогдолгүй, харин танин мэдэхүй болон итгэл үнэмшилд суурилсан хандлага давамгайл нөлөө үзүүлж байна. Энэ нь хотод мэдээллийн сэтгэл хөдлөлийн өнгө аяс илүү хүчтэй нөлөөлдөг бол хөдөөд мэдээллийг логигоор боловсруулах болон өөрийн итгэл үнэмшилд тулгуурлан үнэлэх хандлага илүү чухал байгааг илтгэнэ. Мөн хотын орчинд эмзэг байдлын механизм илүү тодорхой (predictable) байгаа бол хөдөөд илүү тархмал, тогтмол бус шинжтэй байгааг харуулж байна.

Хүснэгт 5. DVI-д нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн, байршлаар

Фактор	Хот	Хөдөө	Тайлбар
Cognitive	✓ ($\beta=0.294$)	✓ ($\beta=0.280$)	Аль алинд нь чухал
Motivated reasoning	✓	✓	Аль алинд нь тогтвортой
Emotional arousal	✓ (хамгийн хүчтэй)	✗ (significant биш)	Гол ялгаа
R^2	0.388	0.190	Хотод тайлбарлах чадвар өндөр

Насны бүлгээр харьцуулсан шинжилгээгээр нас нэмэгдэх хэрээр залуус мэдээллийг илүү өөрийн итгэл үнэмшилд нийцүүлэн тайлбарлах хандлагатай болж, сэтгэл хөдлөлийн шууд нөлөө буурч байна (Хүснэгт 6). Тодруулбал, 16–18 насны бүлэгт гурван хүчин зүйл бүгд статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлж, ялангуяа танин мэдэхүйн хүчин зүйл хамгийн хүчтэй байгаа нь энэ насанд мэдээллийг ойлгох, боловсруулах чадвар болон сэтгэл хөдлөл зэрэгцэн нөлөөлж байгааг илтгэнэ. Харин 19–21 насанд итгэл үнэмшилд суурилсан хандлага ач холбогдолгүй болж, танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлийн хүчин зүйлс давамгайлж байна. 22–25 насанд эсрэгээрээ итгэл үнэмшилдээ суурилах хандлага хамгийн хүчтэй болж, сэтгэл хөдлөлийн нөлөө буурч байна.

Хүснэгт 6. DVI-д нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн, насаар

Фактор	16–18	19–21	22–25	Тайлбар
Cognitive	✓ хамгийн хүчтэй)	✓ (хамгийн хүчтэй)	✓	Бүх насанд тогтвортой
Motivated reasoning	✓	✗	✓ (хамгийн хүчтэй)	Нас ахих тусам өсдөг
Emotional arousal	✓	✓	✗	Нас ахих тусам буурдаг
R ²	0.331	0.250	0.284	Залуу (16–18) хамгийн эмзэг

Байршил ба насны огтлолцлоор хийсэн сегментчилсэн шинжилгээ нь хуурамч мэдээлэлд өртөмтгий байдал нэг төрлийн биш, харин тухайн хүний амьдарч буй орчин болон наснаас хамааран өөр өөр механизмаар бүрэлдэж байгааг тодорхой харуулж байна (Хүснэгт 7). Хотын орчинд сэтгэл хөдлөлд суурилсан нөлөө бүх насанд тогтвортой илэрч, ялангуяа 19–21 насанд хамгийн өндөр түвшинд хүрч байна. Харин 22–25 насанд итгэл үнэмшилд суурилсан хандлага давамгайлж болж байна. Хөдөөгийн орчинд эсрэгээрээ сэтгэл хөдлөлийн нөлөө бараг ажиглагдахгүй бөгөөд залуу насанд итгэл үнэмшилд суурилсан хандлага давамгайлж, нас нэмэгдэх тусам танин мэдэхүйн хүчин зүйл илүү чухал болж байна. Мөн 19–21 насны хөдөөгийн бүлэгт тодорхой нөлөө илрээгүй нь тухайн бүлгийн эмзэг байдал илүү тархмал, эсвэл өөр нэмэлт хүчин зүйлсээр тайлбарлагдах шаардлагатайг илтгэнэ.

Хүснэгт 7. DVI-д нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн, байршил ба насаар

Байршил Нас	Гол драйвер	Хоёрдогч	Нөлөөгүй/сул	Эмзэг байдлын төрөл
Хот 16–18	Танин мэдэхүй	Сэтгэл хөдлөл	Итгэл үнэмшил	Танин мэд. + Сэтгэл хөдлөл
Хот 19–21	Сэтгэл хөдлөл	Танин мэдэхүй	Итгэл үнэмшил	Бүхэлдээ сэтгэл хөдлөлд суурилсан
Хот 22–25	Итгэл үнэмшил	Сэтгэл хөдлөл	Танин мэдэхүй	Итгэл үнэмшил + Сэтгэл хөдлөл
Хөдөө 16–18	Итгэл үнэмшил	Cognitive	Сэтгэл хөдлөл	Итгэл үнэмшилд суурилсан
Хөдөө 19–21	(тодорхойгүй)			Тодорхой биш
Хөдөө 22–25	Танин мэдэхүй	—	Сэтгэл хөдлөл Итгэл үнэмшил	Цэвэр танин мэдэхүй

Хот болон хөдөөгийн дотоод динамикийг нарийвчлан авч үзэхэд хотын залуучуудын хувьд сэтгэл хөдлөлийн нөлөө бүх насанд тогтвортой хадгалагдаж байгаа бол танин мэдэхүйн нөлөө аажмаар буурч, оронд нь итгэл үнэмшилд суурилсан шүүлт нэмэгдэж байна (Хүснэгт 8). Энэ нь мэдээлэл боловсруулах логик танин мэдэхүйн механизмаас итгэл үнэмшилд хөтлөгдсөн хэлбэрт шилжиж байгааг харуулна. Харин хөдөөгийн орчинд сэтгэл хөдлөлийн нөлөө бараг байхгүй, харин насны үе шат бүрд өөр өөр хүчин зүйл давамгайлж, нийтлэг нэг загвар ажиглагдахгүй байна. Энэ нь хөдөөгийн эмзэг байдлын механизм илүү тогтмол бус, тархмал шинжтэй байгааг илтгэж байна.

Хүснэгт 8. DVI-д нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн, байршил ба насаар

Фактор	16–18	19–21	22–25	Чиг хандлага
Хотод				
Танин мэдэхүй	✓ (хамгийн хүчтэй)	✓	✗	↓ буурна
Итгэл үнэмшил	✗	✗	✓ (хамгийн хүчтэй)	↑ нэмэгдэнэ
Сэтгэл хөдлөл	✓	✓ (хамгийн хүчтэй)	✓	тогтвортой
Загварын хүч	Маш өндөр	Өндөр	Өндөр	
Хөдөөд				
Танин мэдэхүй	✓	✗	✓ (хамгийн хүчтэй)	U-shape
Итгэл үнэмшил	✓ (хамгийн хүчтэй)	✗	✗	↓ буурна
Сэтгэл хөдлөл	✗	✗	✗	Бараг нөлөөгүй
Загварын хүч	Дунд	Сул	Дунд	

Эдгээр үр дүнгээс харахад хуурамч мэдээлэлд өртөмтгий байдал нь зөвхөн түвшний (high/low) асуудал биш, харин ямар механизмаар бүрэлдэж байгаагаас хамаарах илүү нарийн бүтэцтэй ойлголт байна. Иймд залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг бууруулах интервенцийг төлөвлөхдөө зөвхөн эмзэг байдлын түвшнээр бус, харин тухайн бүлгийн эмзэг байдал ямар хүчин зүйлээр илүү тайлбарлагдаж байгаа болон ямар механизм давамгайл нөлөөлж байгаад үндэслэх нь зүйтэй байна. Тухайлбал, хотын орчинд илүү тодорхой, зорилтот интервенц (ялангуяа сэтгэл хөдлөлд суурилсан мэдээллийн нөлөөг бууруулах чиглэлээр) хэрэгжүүлэх шаардлагатай бол хөдөөгийн орчинд суурь чадвар (мэдээллийг ялган таних, эх сурвалжийг үнэлэх, шүүн боловсруулах) хөгжүүлэх, мөн нэмэлт судалгаанд суурилсан уян хатан арга хэмжээ илүү үр дүнтэй байх магадлалтай байна.

1.3.2.3 Танин мэдэхүйн хүчин зүйлсийн нөлөө

Залуучуудын танин мэдэхүйн хүчин зүйлс нь хуурамч мэдээллийн эмзэг байдалд нь нөлөөлж буй эсэхийг тодруулах зорилгоор залуучууд мэдээллийг (i) хэр анхааралтай уншиж, түүнийгээ санаж буй эсэх, (ii) эргэлзэлгүйгээр итгэж буй эсэх, мөн (iii) олон давтагдсан мэдээлэлд илүү итгэж буй эсэхийг шалгаж, 0-100 оноогоор илэрхийлэгдэх индекс боловсруулав. Индекс нь тэнцүү жинтэй гурван дэд үзүүлэлтээс бүрдэх ба тус бүр нь туршилтын асуултын үр дүн (60%) болон өөрийн үнэлгээ (40%)-ний нийлбэрээр тооцсон (Хүснэгт 9). Оноо нэмэгдэх тусам танин мэдэхүйн эмзэг байдал нь нэмэгдэж байна гэж ойлгоно.

Хүснэгт 9. Танин мэдэхүйн индекс боловсруулсан аргачлал, үр дүн

Дэд үзүүлэлт	Туршилтын асуулт (60%)	Өөрийн үнэлгээ (40%)	Үр дүн
Мэдээлэлд эргэлзэлгүйгээр үнэн гэж итгэх байдал	Оролцогчдод мэдээлэл харуулж шууд итгэсэн эсэх, эргэлзсэн эсэх зэрэг анхны сэтгэгдлийг нь тодруулсан.	Оролцогчдоор мэдээллийг хараад шууд итгэх хандлагатай байдаг эсэхийг нь үнэлүүлсэн.	50.3 (SD = 12.5)
Давтагдсан мэдээллийг үнэн мэт ойлгох байдал	Оролцогчдод нэг ижил агуулгатай мэдээллийг гурван өөр хэлбэрээр харуулж, тус мэдээлэл үнэн эсвэл худал болохыг ялгуулсан.	Оролцогчдоор олон давтагдсан мэдээлэлд илүү итгэх хандлагатай байдаг эсэхийг нь үнэлүүлсэн.	49.9 (SD = 10.9)
Мэдээллийг анхааралтай шалгахгүйгээр хүлээн авах байдал	Оролцогчид харсан мэдээллийнхээ доторх тодорхой баримт, нарийн мэдээллийг хэр сайн санаж байгааг тестээр шалгасан.	Оролцогчдоор уншсан мэдээллийнхээ агуулга, тоо баримтыг хэр санадаг болохыг нь үнэлүүлсэн.	44.1 (SD = 14.9)
Дундаж		48.1	

Ингэж шалгахад танин мэдэхүйн индекс нь **400 оролцогчдын дунд дунджаар 48.1** байсан ба 22.5-74.2 хооронд хэлбэлзэж байв. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцсон залуучуудын дунд мэдээллийг шууд үнэн гэж хүлээн авах, давтагдсан мэдээлэлд илүү итгэх, мэдээллийн агуулгыг нарийвчлан шалгахгүй байх зэрэг хандлага түгээмэл ажиглагдав.

Мөн танин мэдэхүйн эмзэг байдал нь оролцогчдын зарим нийгэм-эдийн засаг, хүн амзүйн шинжтэй холбоотой байв. Тухайлбал, боловсролын түвшин ($p = -.139$, $p < .05$) болон өрхийн орлого ($p = -.102$, $p < .05$) өндөр байх тусам танин мэдэхүйн эмзэг байдал бага байх хандлага ажиглагдсан. Үүнээс гадна байршлаас хамаарсан ялгаа ($F(2, 397) = 3.55$, $p = .030$) ажиглагдсан ба сумын төвд амьдарч буй оролцогчдын танин мэдэхүйн индексийн дундаж ($M = 49.59$) нь Улаанбаатар ($M = 47.83$) болон аймгийн төвийн ($M = 46.62$) оролцогчдоос харьцангуй өндөр буюу ялимгүй эмзэг байв.

Харин энэхүү танин мэдэхүйн хүчин зүйлс залуучуудын хуурамч мэдээллийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тодруулбал, судалгааны багийн зүгээс танин мэдэхүйн (эмзэг байдал) хүчин зүйлс хуурамч мэдээллийн эмзэг байдлын индекст нөлөөлж буй эсэхийг шугаман регрессийн

шинжилгээгээр шалгахад статистикийн ач холбогдолтой эерэг нөлөөтэй байв ($\beta = 0.403, p < 0.001$). Загвар нийтдээ өндөр ач холбогдолтой байсан ($F(1, 398) = 77.06, p < .001$) нь:

- I. мэдээллийг анхааралтай шалгахгүйгээр хүлээн авах,
- II. эргэлзэлгүйгээр үнэн гэж итгэх,
- III. давтагдсан мэдээллийг үнэн мэт ойлгох танин мэдэхүйн хандлагууд нийлж, хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг мэдэгдэхүйц нэмэгдүүлж байгааг харуулж байна.

Танин мэдэхүйн хүчин зүйлийг бүрдүүлж буй дэд хүчин зүйлсийг хамтад нь нэг регрессийн загварт зэрэг оруулж, хуурамч мэдээллийн эмзэг байдалд нөлөөлж буй эсэхийг шалгахад мэдээлэлд эргэлзэлгүйгээр үнэн гэж итгэх хандлага хамгийн хүчтэй нөлөөтэй байсан бол давтагдсан мэдээлэлд итгэх хандлага дунд зэргийн нөлөөтэй байв. Харин мэдээллийг анхааралтай шалгахгүйгээр хүлээн авах хандлага нөлөө үзүүлээгүй (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Танин мэдэхүйн дэд үзүүлэлтүүдийн DVI-д үзүүлэх регрессийн шинжилгээний үр дүн

Дэд үзүүлэлт	Статистик үр дүн	Хуурамч мэдээллийн эмзэг байдалд үзүүлэх нөлөө
Мэдээлэлд эргэлзэлгүйгээр үнэн гэж итгэх байдал	$\beta = 0.428, p < .001$	Хүчтэй эерэг нөлөөтэй
Давтагдсан мэдээллийг үнэн мэт ойлгох байдал	$\beta = 0.190, p < .001$	Дунд зэргийн эерэг нөлөөтэй
Мэдээллийг анхааралтай шалгахгүйгээр хүлээн авах байдал	$p = .435$	Ач холбогдолтой нөлөө илрээгүй

Тэмдэглэл. Гурван дэд үзүүлэлтийг нэг регрессийн загварт зэрэг оруулсан. Загвар нийтдээ статистикийн ач холбогдолтой байсан ($F(3, 396) = 44.83, p < .001$) бөгөөд DVI-ийн 25.4%-ийг тайлбарласан ($R^2 = .254$). β нь тухайн дэд үзүүлэлтийн нөлөөний чиглэл, харьцангуй хүчийг илэрхийлнэ.

Залуус мэдээллийг анх харахдаа л автоматаар “үнэн” гэж хүлээн авах тусам хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал нэмэгдэж байна. Үр дүнгээс харахад, оролцогч мэдээллийг анхааралтай уншсан эсэхээс илүүтэй, тухайн мэдээлэлд анхны мөчид шүүмжлэлтэй хандсан уу, эсвэл шууд үнэн гэж хүлээн авсан уу гэдэг нь илүү чухал байна. Тиймээс залуус мэдээллийг анх хүлээн авах үедээ эргэлзэх, шалгах, түр азнах дадалтай буюу шүүмжлэлт сэтгэлгээтэй байх нь хуурамч мэдээллийн эрсдэлийг бууруулах боломжтой.

Нэг ижил агуулгатай мэдээлэл олон удаа давтагдах тусам хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал нэмэгдэх хандлага мөн ажиглагдав. Өөрөөр хэлбэл, хуурамч мэдээллийн эрсдэл зөвхөн нэг удаагийн мэдээллээр хязгаарлагдахгүй, харин ижил санаа олон янзын хэлбэрээр давтагдах үед илүү хүчтэй болдог болохыг харуулж байна.

Эдгээрээс дүгнэхэд танин мэдэхүйн хүчин зүйлс нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг тайлбарлахад чухал үүрэгтэй байна. Иймээс залуучуудад чиглэсэн арга хэмжээг зөвхөн мэдээлэл шалгах техник чадвараар хязгаарлахгүй, харин мэдээлэлд эргэлзэж хандах, түүнд итгэхээс өмнө түр азнах, олон давтагдсан мэдээллийг автоматаар үнэн гэж хүлээн авахгүй байх дадлыг хөгжүүлэхэд чиглэвэл илүү үр дүнтэй байж болох юм.

2. Итгэл үнэмшилд тулгуурлах хандлагын нөлөө (Motivated reasoning)

Итгэл үнэмшилдээ тулгуурлан мэдээллийг хүлээн авах хандлагыг Хүснэгт 11-д харуулсан 4 дэд хүчин зүйлийн дагуу хэмжсэн.

Хүснэгт 11. Итгэл үнэмшилд тулгуурлах хандлагын индекс боловсруулсан аргачлал, дундаж үр дүн

Дэд үзүүлэлт	Туршилтын асуулт (60%)	Өөрийн үнэлгээ (40%)	Индексийн дундаж
Бүлгийг даган дуурайх хандлага	Олон нийтийн хариу үйлдлийн түвшин ялгаатай (Like, Share өндөр болон бага) постуудыг харуулж,	Бусдын байр суурь, олон нийтийн хандлага нь өөрийн үзэл бодолд хэрхэн нөлөөлдөг талаарх	54 (SD = 14.84)

(social conformity index)	оролцогчдын мэдээллийг хэрхэн хүлээн авч буйг харьцуулсан.	бодомжуудтай санал нийлэх түвшнийг үнэлүүлсэн.	
Эх сурвалжид шүүлтүүргүй итгэх байдал (trust in sources/authorities index)	Мэдээллийн эх сурвалжийг тодорхой харуулсан болон нуусан байдлаар ялгаатай контент үзүүлж, мэдээлэлд итгэх түвшний ялгааг харьцуулсан.	Мэдээллийг хэн, ямар байгууллагаас хүргэж буй нь тухайн мэдээлэлд итгэхэд хэр чухал нөлөөтэй талаарх бодомжуудтай санал нийлэх түвшнийг үнэлүүлсэн.	50.05 (SD = 15.07)
Өөрийн итгэл үнэмшилд нийцүүлэх байдал (identity-oriented reasoning index)	Оролцогчдын суурь итгэл үнэмшлийг урьдчилан тодруулсны дараа түүнд нийцтэй болон зөрчилтэй агуулгатай мэдээлэл үзүүлж, хариу үйлдлийг нь харьцуулсан.	Өөрийн итгэл үнэмшилтэй зөрчилдөх мэдээллийг хүлээн авахад хэр хүндрэлтэй байдгийг үнэлүүлсэн.	48.06 (SD = 20.44)
Залруулгыг хүлээн авахаас татгалзах байдал (resistance to correction index)	Өмнө үзүүлсэн мэдээлэлтэй холбоотой баримт шалгалтын залруулгыг үзүүлж, оролцогчид өмнөх итгэл үнэмшлээ өөрчилж буй эсэхийг шалгасан.	Өөрийгөө буруу ойлгосон байснаа мэдсэн үед үзэл бодлоо өөрчлөх нь хэр хүндрэлтэй санагддагийг үнэлүүлсэн.	36.73 (SD=12.82)
Дундаж		47.21	

Дэд индексүүдийн дундаж оноог авч үзвэл бусдыг даган дуурайх хандлага хамгийн өндөр буюу 54.0 оноо (SD=14.84) гарсан нь бусдын хандлага, олон нийтийн дэмжлэг, өндөр хандалт зэрэг нийгмийн нөлөөлөл залуучуудын мэдээллийг үнэлэхэд харьцангуй хүчтэй нөлөөлж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл бусад хүмүүс тухайн асуудлаар ямар байр суурьтай байх нь залуучууд уг мэдээллийг хэрхэн хүлээж авахад хүчтэй нөлөөтэй байна.

Мөн мэдээллийн эх сурвалж болон нөлөө бүхий этгээдэд итгэх байдлыг хэмжсэн эх сурвалжид шүүлтүүргүй итгэх индексийн дундаж 50.05 оноо (SD=15.07) байгаа нь эх сурвалжийн нэр хүнд, эрх мэдэл мэдээллийг үнэн зөв гэж хүлээн авахад дунд түвшний нөлөө үзүүлж байгааг илтгэнэ.

Харин өөрийн суурь итгэл үнэмшилд нийцүүлэх байдлын дундаж 48.06 оноо (SD=20.44) гарсан нь оролцогчид өөрийн өмнөх итгэл үнэмшил, үнэт зүйлтэй нийцсэн мэдээллийг илүү үнэн гэж хүлээн авах хандлага дунд түвшинд байгааг харуулж байна. Энэхүү үзүүлэлтийн стандарт хазайлт харьцангуй өндөр байгаа нь оролцогчдын хооронд ялгаа их байгааг, өөрөөр хэлбэл зарим бүлэгт өөрийн суурь итгэл үнэмшилд нийцүүлэх байдал илүү хүчтэй илэрч байгааг илтгэнэ.

Залруулгыг хүлээн авахаас татгалзах байдал хамгийн бага буюу 36.73 оноо (SD=12.82) гарсан нь оролцогчдын тодорхой хэсэг нь залруулга, шалгасан баримтын мэдээллийг хүлээн авч анхны буруу ойлголтоо засах хандлагатай байгааг харуулж байна. Нийт итгэл үнэмшилд суурилсан шүүлт (motivated reasoning)-ийн нийлмэл индексийн дундаж 47.21 оноо (SD=10.25) байгаа нь залуучуудын хувьд мэдээллийг үнэлэхдээ зөвхөн логик, баримтад бус, харин нийгмийн нөлөөлөл, эх сурвалжид итгэх байдал, өмнөх итгэл үнэмшил зэрэг хүчин зүйлс тодорхой хэмжээнд нөлөөлж байгааг илэрхийлж байна.

Итгэл үнэмшилд тулгуурлах хандлагын (motivated reasoning) нийлмэл индекс нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын индекс (DVI)-д нөлөөтэй эсэхийг шалгах зорилгоор хийсэн регрессийн шинжилгээний үр дүнд статистикийн ач холбогдолтой, дунд зэргээс дээш нөлөөтэй болох нь тогтоогдлоо ($\beta = 0.395$, $p < 0.001$). Өөрөөр хэлбэл, итгэл үнэмшилд суурилсан шүүлтийн түвшин өсөх тусам залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал нэмэгдэх хандлагатай байна.

Итгэл үнэмшилд тулгуурлах хандлагын нийлмэл индекс нь залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын 15.6%-ийг тайлбарлаж байгаа нь энэхүү хүчин зүйл DVI-д мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Энэ нь хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын тодорхой хэсэг нь хүмүүс мэдээллийг

хэрхэн хүлээн авч, тайлбарлаж, үнэлж байгаатай холбоотой гэсэн үг юм. Мөн итгэлцлийн интервал бүхэлдээ эерэг утгатай гарсан нь уг нөлөө санамсаргүй бус, харьцангуй тогтвортой, найдвартай байгааг илтгэнэ.

Эдгээр үр дүнгээс харахад хүмүүс мэдээллийг зөвхөн логик болон баримтад тулгуурлан үнэлдэггүй, харин өөрийн өмнөх итгэл үнэмшил, нийгмийн нөлөөлөл, эх сурвалжид итгэх байдал зэрэг танин мэдэхүйн болон сэтгэл зүйн хүчин зүйлсээр дамжуулан хүлээн авч байна. Тухайлбал:

- өөрийн итгэл үнэмшилтэй нийцсэн мэдээллийг илүү үнэн гэж үзэх,
- бусдын байр суурь, олон нийтийн хандлагыг дагах,
- эрх мэдэлтэй эсвэл танил эх сурвалжид шүүлтүүргүй итгэх,
- мөн буруу мэдээллийг залруулсан ч анхны ойлголтоо хадгалах хандлага зэрэг зан үйлүүд нийлээд залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг системтэйгээр нэмэгдүүлж байгааг харуулж байна.

Гэсэн хэдий ч энэхүү нийлмэл индексийг бүрдүүлэгч дэд хүчин зүйлсийн нөлөө жигд биш бөгөөд (Хүснэгт 12) тэдгээр нь өөр өөр механизмаар үйлчилж байна.

Хүснэгт 12. Итгэл үнэмшилд суурилсан шүүлтийн дэд үзүүлэлтүүдийн DVI-д үзүүлэх регрессийн шинжилгээний үр дүн

	Дэд үзүүлэлт	Үр дүн	Үзүүлэлт
1	Итгэл үнэмшилтэй зөрчилдөх мэдээлэлд хариулах байдал	Статистик ач холбогдолтой нөлөөгүй	DVI-т нөлөөлөхүйц хамаарал илрээгүй ($p > 0.05$), тайлбарлах чадвар маш сул ($R^2 \approx 0.001$)
2	Бусдыг даган дуурайх хандлага	Статистик хамааралтай	Эерэг, дунд зэргийн нөлөөтэй ($\beta = 0.375$, $p < 0.001$), DVI-ийн 14.0%-ийг тайлбарласан
3	Эх сурвалжид итгэх хандлага	Статистик хамааралтай	Эерэг, дунд зэргийн нөлөөтэй ($\beta = 0.340$, $p < 0.001$), DVI-ийн 11.5%-ийг тайлбарласан
4	Залруулгыг хүлээн авахаас татгалзах байдал	Статистик хамааралтай	Эерэг, дунд зэргээс дээш нөлөөтэй ($\beta = 0.376$, $p < 0.001$), DVI-ийн 14.2%-ийг тайлбарласан

Юуны өмнө, итгэл үнэмшилтэй зөрчилдөх мэдээлэлд хэрхэн хариулах буюу identity-oriented reasoning нь DVI-д статистикийн ач холбогдолтой нөлөөгүй байна ($R^2 \approx 0.005$, $p > 0.05$). Судалгаанд оролцогчдын суурь итгэл үнэмшил болон түүнтэй нийцсэн/зөрчилдсөн контентын харилцан нөлөөг шалгахад уг загвар нийтдээ тайлбарлах чадваргүй гарсан. Энэ нь хүмүүс өөрийн итгэл үнэмшилд нийцэх мэдээллийг илүүд үзэх хандлагатай байж болох ч энэ үзүүлэлт дангаараа хуурамч мэдээлэлд өртөх байдлыг тодорхойлох хангалттай хүчин зүйл биш гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, өөрийн итгэл үнэмшилдээ тулгуурлах хандлага нь бие даасан хүчин зүйл бус, харин бусад хүчин зүйлстэй хавсарсан үед илүү тод илэрдэг байх магадлалтай.

Харин нийгмийн нөлөөнд автах хандлага (social conformity) нь DVI-д статистикийн ач холбогдолтой, бодит нөлөө үзүүлж байна ($F(1,398) = 65.037$, $p < .001$). Өөрөөр хэлбэл, бусдын байр суурь, үйлдэлд илүү нийцэх хандлагатай хүмүүс хуурамч мэдээллийг хүлээн авах, түгээх магадлал өндөр байна. Энэ нь мэдээллийг бие даан шүүн тунгаахаас илүүтэй “олонх юу гэж байна вэ” гэдэг дохиогоор үнэлэх үед буруу мэдээлэлд өртөх эрсдэл нэмэгддэг гэсэн онолын тайлбартай нийцэж байна. Гэсэн хэдий ч туршилтын түвшинд лайк, шэйрийн тоо зэрэг энгийн дохио нь дангаараа статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлээгүй ($p > 0.05$). Энэ нь нийгмийн нөлөө нь зөвхөн ил харагдах engagement metrics-ээр бус, харин илүү гүнзгий сэтгэлзүйн болон нийгмийн контекстэй уялдан үйлчилдгийг илтгэнэ.

Эх сурвалжид итгэх хандлага (source trust) мөн адил DVI-д нөлөөтэй байна ($F(1,398) = 51.854$, $p < .001$). Гэхдээ энэ нөлөө нь хамгаалах бус, харин хоёр талт шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, хүмүүс эх

сурвалжид шүүлтүүргүй итгэх үед, тэрхүү эх сурвалж буруу эсвэл найдваргүй байвал хуурамч мэдээлэлд өртөх эрсдэл нэмэгддэг. Иймээс source trust нь зөвхөн “итгэх” асуудал биш, харин “ямар эх сурвалжид, ямар шалгуураар итгэж байна вэ” гэдгээс шууд хамаарч байна. Туршилтын нөхцөлд эх сурвалжийг ил тод харуулах (authority cue) нь мэдээлэлд итгэх түвшинд статистикийн ач холбогдолтой ялгаа үүсгээгүй ($p = .853$) нь энэ хандлага нь тухайн агшны дохионоос илүүтэй, хувь хүний тогтсон мэдээлэл боловсруулах хэв маягтай холбоотойг харуулж байна.

Эцэст нь, залруулгыг хүлээн авахаас татгалзах байдал (resistance to correction) нь хамгийн хүчтэй дэд үзүүлэлтүүдийн нэг болох нь харагдаж байна ($F(1,398) = 65.697, p < .001$). Энэ нь хүмүүс нэгэнт буруу мэдээлэлд итгэсэн тохиолдолд түүнийг засах оролдлогод эсэргүүцэл үзүүлэх хандлага нь эмзэг байдлыг нэмэгдүүлж, улмаар буруу мэдээллийн нөлөөг баталгаажуулж, урт хугацаанд хадгалах нөхцөл бүрдүүлж байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал нь зөвхөн анхны итгэл биш, харин залруулгыг хүлээн авах чадвартай шууд холбоотой байна.

Эдгээр үр дүнгээс харахад итгэл үнэмшилд тулгуурлах хандлага нь нэг төрлийн бус, харин дотооддоо ялгаатай механизмуудаас бүрдсэн нийлмэл бүтэцтэй ойлголт байна. Тухайлбал,

- Бусдыг даган дуурайх болон залруулгыг хүлээн авахаас татгалзах байдлууд нь хамгийн хүчтэй нөлөөтэй хүчин зүйлс,
- мэдээллийн эх сурвалж болон эрх мэдэл бүхий этгээдэд итгэх байдал нь контекстээс хамааран хоёр талт нөлөөтэй,
- суурь итгэл үнэмшилдээ суурилж хүлээн авах байдал нь дангаараа хангалттай тайлбарлагч биш байна.

Иймд залуучууд уруу чиглэсэн интервенцийг зөвхөн “итгэл үнэмшил бууруулах” ерөнхий хандлагаар бус, харин эдгээр ялгаатай механизмд чиглэсэн байдлаар төлөвлөх шаардлагатай. Тухайлбал, нийгмийн нөлөөнд суурилсан буруу мэдээллийн тархалтыг бууруулах, эх сурвалжийг шүүн үнэлэх чадварыг хөгжүүлэх, мөн залруулгыг үр дүнтэй хүлээн авах сэтгэлзүйн механизм (debiasing strategies) - ийг дэмжих нь илүү өндөр үр нөлөөтэй байх боломжтой байна.

3. Сэтгэл хөдлөлийн өдөөлт (Emotional arousal)

Сэтгэл хөдлөлийн өдөөлтөд суурилсан мэдээлэлд үзүүлэх хариу үйлдлийг Хүснэгт 13-д харуулсан хоёр дэд хүчин зүйлийн дагуу хэмжсэн.

Хүснэгт 13. Сэтгэл хөдлөлийн өдөөлтийн индекс тооцсон аргачлал, дундаж үр дүн

Дэд үзүүлэлт	Туршилтын асуулт (60%)	Өөрийн үнэлгээ (40%)	Индексийн дундаж
Өндөр сэтгэл хөдлөлийн өдөөлт (high-arousal emotions index)	Айдас, уур, түгшүүр, жигшил, догдлол зэрэг хүчтэй сэтгэл хөдлөл өдөөх мэдээлэл болон хүмүүсийн сэтгэгдлийг харуулж, оролцогчдын тухайн мэдээлэлд үзүүлж буй хариу үйлдлийг шалгасан.	Айдас, уур, түгшүүр төрүүлсэн мэдээлэл нь өөрийн анхаарлыг илүү их татдаг эсэх талаарх өөрийн үнэлгээг тодруулсан.	56.24 оноо (SD= 16.58)
Ёс суртахууны өдөөлт (Moral Index)	Ёс зүйн болон ёс суртахууны хувьд буруу, хүлээн зөвшөөрөх боломжгүй агуулгатай мэдээлэл үзүүлж, оролцогчдын хариу үйлдлийг шалгасан.	“Шударга бус”, “эрх мэдлээ урвуулан ашигласан”, “ёс зүйгүй”, “буруу” гэж мэдрэгдсэн мэдээлэлд хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг талаарх өөрийн үнэлгээг тодруулсан.	44.01 оноо (SD = 16.52)
Дундаж		50.13 (SD=13.98)	

Дэд индексүүдийн дундаж оноог авч үзвэл хүчтэй сэтгэл хөдлөлийн өдөөлт хамгийн өндөр буюу 56.24 оноо (SD=16.58) гарсан нь залуучууд сэтгэл хөдлөл өдөөхөд чиглэсэн мэдээлэлд илүү эмзэг бөгөөд

айдас, бухимдал, түгшүүр, уур зэрэг өндөр идэвхжилтэй сэтгэл хөдлөлүүд үзүүлж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, хүчтэй сэтгэл хөдлөл төрүүлсэн мэдээлэл нь залуучуудын анхаарлыг илүү татаж, тухайн мэдээлэлд шууд хариу үйлдэл үзүүлэх магадлалыг нэмэгдүүлж байна.

Харин ёс суртахууны индексийн дундаж 44.01 оноо ($SD = 16.52$) гарсан нь ёс суртахуун, зөв буруу гэсэн үнэлэмжтэй холбоотой сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл дунд түвшинд илэрч байгааг илтгэнэ. Энэ нь хүмүүсийн үнэт зүйл, ёс суртахууны байр суурьтай нийцсэн агуулга нь мэдээллийг үнэн гэж хүлээн авахад тодорхой хэмжээнд нөлөөлж байгааг харуулж байна.

Нийт сэтгэл хөдлөлийн өдөөлтийн нийлмэл индексийн дундаж 50.13 оноо ($SD=13.98$) байгаа нь залуучууд мэдээллийг үнэлэхдээ зөвхөн логик, баримтад бус, харин сэтгэл хөдлөлийн хариу үйлдэлд тодорхой хэмжээнд нөлөөлж байгааг харуулна. Тодруулбал, хүчтэй сэтгэл хөдлөл төрүүлсэн, эсвэл ёс суртахууны мэдрэмжийг өдөөсөн мэдээлэл нь залуучуудын мэдээлэлд итгэх, хариу үйлдэл үзүүлэх байдалд нөлөөлөх хандлагатай байна.

Сэтгэл хөдлөлийн өдөөлтийн нийлмэл индекс нь DVI-д нөлөөтэй эсэхийг шалгах зорилгоор хийсэн регрессийн шинжилгээний үр дүнд статистикийн ач холбогдолтой шууд нөлөөтэй болох нь тогтоогдсон ($\beta = 0.369$, $p < .001$). Өөрөөр хэлбэл, мэдээлэл залуучуудад илүү хүчтэй сэтгэл хөдлөл төрүүлэх тусам тухайн залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал нэмэгдэх хандлагатай байна.

Шинжилгээний үр дүнгээр сэтгэл хөдлөлийн өдөөлтийн нийлмэл индекс нь залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын 13.6%-ийг тайлбарлаж байгаа нь энэхүү хүчин зүйл DVI-д мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Энэ үзүүлэлт нь дэд хүчин зүйлсийг тусад нь авч үзсэн үр дүнгээс (өндөр сэтгэл хөдлөл: 12.3%, ёс суртахууны өдөөлт: 7.4%) өндөр байгаа нь сэтгэл хөдлөлийн эдгээр хоёр хэлбэр хоорондоо харилцан бэхжиж, нийлмэл нөлөө үүсгэж байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын тодорхой хэсэг нь мэдээлэл хүмүүсийн сэтгэл хөдлөлийг хэр хүчтэй өдөөж байгаатай холбоотой байна.


Хоёр хүчин зүйлийн нөлөөг харьцуулж авч үзвэл, өндөр өдөөлттэй сэтгэл хөдлөл ($\beta = 0.351$) нь ёс суртахуунд суурилсан өдөөлтөөс ($\beta = 0.272$) илүү хүчтэй нөлөөтэй байна. Мөн итгэлцлийн интервал бүхэлдээ эерэг утгатай гарсан нь энэхүү нөлөө санамсаргүй бус, харьцангуй тогтвортой, найдвартай байгааг харуулж байна. Энэ нь сэтгэл хөдлөл зөвхөн дагалдах хүчин зүйл биш, харин мэдээлэл боловсруулах үйл явцад шууд нөлөөлж, хүмүүсийг аналитик үнэлгээнээс илүү хурдан, шууд, шүүлт багатай хариу үйлдэл үзүүлэхэд хүргэдэг чухал механизм болохыг илтгэж байна.

Хүснэгт 14. Ёс суртахууны өдөөлтийн дэд үзүүлэлтүүдийн DVI-д үзүүлэх регрессийн шинжилгээний үр дүн

	Дэд үзүүлэлт	Үр дүн	Үзүүлэлт
1	Өдөөгдсөн сэтгэл хөдлөл	Статистик хамааралтай	Эерэг, дунд зэргийн нөлөөтэй ($\beta = 0.351$, $p < 0.001$), DVI-ийн 12.3%-ийг тайлбарласан
2	Ёс суртахуун, сэтгэл хөдлөлийн өдөөлт	Статистик хамааралтай	Эерэг, дунд зэргийн нөлөөтэй ($\beta = 0.272$, $p < 0.001$), DVI-ийн 7.4%-ийг тайлбарласан

Өндөр сэтгэл хөдлөлийн өдөөлтийг туршилтаар шалгахад оролцогчдын 73.7% нь мэдээлэл уншсаны дараа дунд болон түүнээс дээш түвшний сөрөг сэтгэл хөдлөл мэдэрч, үүнээс 26.3% нь хүчтэй болон маш хүчтэй хариу илэрхийлсэн байна (Дүрс 7). Энэ нь судалгаанд ашигласан контентууд бодит нөхцөлд ажиглагддаг өндөр сэтгэл хөдлөлийн өдөөлтийг амжилттай үүсгэснийг харуулна. Гэхдээ хамгийн чухал нь, оролцогчдын зөвхөн 25.5% нь “үнэн эсэхийг шалгах хэрэгтэй” гэж хариулсан бол үлдсэн хэсэг нь айдас, түгшүүр, дургүйцэл зэрэг шууд сэтгэл хөдлөлд суурилсан хариу үйлдэл үзүүлсэн байна. Энэ нь мэдээллийг шүүн тунгаах чадвар байгааг үгүйсгэхгүй ч, бодит нөхцөлд сэтгэл хөдлөл давамгайлж байгааг харуулж байна.

Дүрс 7. Мэдээллийг уншаад санаа зовох, түгших, бухимдах мэдрэмж төрсөн, %



Дүрс 8. Мэдээллийг уншсаны дараах мэдрэмж, %



Үүнийг бататган, сэтгэл хөдлөлийн түвшин болон анхны хариу үйлдлийн хооронд статистикийн ач холбогдолтой холбоо ($\chi^2(28) = 246.491$, $p < .001$; Cramer's $V = 0.278$) илэрсэн. Сэтгэл хөдлөлийн түвшин өндөр байх тусам оролцогчид аналитик үнэлгээ хийхээс илүү шууд сэтгэл хөдлөлд суурилсан хариу үзүүлэх магадлал нэмэгдэж, харин сэтгэл хөдлөлийн түвшин бага үед мэдээллийг шалгах, баталгаажуулах хандлага илүү ажиглагдсан. Энэ нь сэтгэл хөдлөл нь зөвхөн мэдрэмж бус, харин шийдвэр гаргах механизмыг өөрчлөх нөлөөтэйг харуулж байна.

Мөн регрессийн шинжилгээгээр сэтгэл хөдлөлийн өдөөлтийн индекс нь DVI-д статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлж ($F(1,398) = 55.885$, $p < .001$), сэтгэл хөдлөлийн өндөр өдөөлт нь хурдан, шүүлт багатай шийдвэр гаргалтыг өдөөдөг гэсэн онолын тайлбарыг баталж байна.

Ёс суртахуун, сэтгэл хөдлөлийн өдөөлтийн хувьд (moral-emotional triggers) үр дүн илүү нарийн, хоёр талт шинжтэй гарсан. Оролцогчдын 20–24% нь мэдээллийг шууд хүлээн авах бус, эхлээд шалгах хандлага илэрхийлсэн нь тодорхой хэмжээнд аналитик хандлага байгааг харуулж байна. Гэвч үүний зэрэгцээ уур бухимдал, айдас, жигшил, ёс суртахууны өдөөлт зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийн хариу өндөр хувь эзэлж байгаа нь ёс суртахууны агуулгатай мэдээлэл нь хүмүүсийн сэтгэл хөдлөлийг өргөн хүрээнд өдөөж байгааг илтгэнэ.

Хамгийн сонирхолтой нь, ийм төрлийн мэдээллийг түгээх шалтгааныг асуухад оролцогчид өөрсдийгөө ихэвчлэн “prosocial” буюу “бусдад анхааруулах”, “нийгэмд хэрэгтэй” зорилгоор түгээдэг гэж тайлбарласан. Харин шууд сэтгэл хөдлөлөөс үүдэн түгээх (2.5–4.5%) болон бусдын хариуг харах зорилго (3.5–5.0%) зэрэг илүү импульс шинжтэй шалтгаанууд бага хувьтай байсан. Гэсэн хэдий ч энэ нь бодит зан үйлээс зөрөх (social desirability bias) магадлалтай бөгөөд хүмүүс өөрсдийн үйлдлийг илүү хариуцлагатайгаар тайлбарлах хандлагатай байгааг илтгэж байна.

Ёс суртахуун, сэтгэл хөдлөлийн өдөөлт нь мөн DVI-д статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлж байгаа ($F(1,398) = 31.805$, $p < .001$) боловч тайлбарлах чадвар нь харьцангуй бага байна. Гэсэн хэдий ч регрессийн загвар бүхэлдээ ач холбогдолтой гарсан нь уг хүчин зүйл бодит нөлөөтэй болохыг баталж байна. Өөрөөр хэлбэл, ёс суртахууны өдөөлт нь дангаараа хамгийн хүчтэй хүчин зүйл биш боловч бусад хүчин зүйлтэй хавсарсан үед эмзэг байдлыг нэмэгдүүлэх чухал үүрэгтэй.

Эдгээр үр дүнг нэгтгэн дүгнэвэл, сэтгэл хөдлөлийн нөлөө нь нэг төрлийн бус, харин хоёр өөр түвшинд үйлчилж байна. Нэгдүгээрт, өндөр сэтгэл хөдлөл нь хүмүүсийг шууд, хурдан, шүүлт багатай хариу үйлдэл рүү түлхдэг “fast pathway” үүсгэдэг. Хоёрдугаарт, ёс суртахууны өдөөлт нь тухайн мэдээллийг “ёс суртахууны асуудал” болгон хувиргаж, хүмүүсийг тухайн мэдээлэлд хариу үйлдэл үзүүлэх сэдлийг бий болгодог. Эдгээр нь хамтдаа мэдээллийг зөвхөн ойлгох биш, харин мэдрэх, хариулах, түгээх үйл явцыг бүхэлд нь өөрчилж байна.


Иймээс хуурамч мэдээллийн эмзэг байдал нь зөвхөн мэдээллийг буруу ойлгох асуудал биш, харин сэтгэл хөдлөлийн нөлөөгөөр өдөөгдсөн хурдан, импульс шинжтэй шийдвэр гаргалтын үр дүн гэж ойлгох шаардлагатай. Энэ нь интервенцийг зөвхөн танин мэдэхүйн чадвар хөгжүүлэхэд төвлөрүүлэхээс гадна, сэтгэл хөдлөлийн зохицуулалт, өндөр өдөөлттэй контентыг таних, түр хойшлуулах (pause) зан үйлийг дэмжих зэрэг сэтгэлзүйн механизмуудыг давхар хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

3.3. Бүлгийн мэдээллийн орон зай

Хувь хүний мэдээллийн зан үйл нь тухайн хүний онцлог хүчин зүйлсээс хамаарахын сацуу бүлгийн мэдээллийн орон зай, тэдгээр дэх оролцогчдын нөлөөгөөр хувьсан тодорхойлогддог. Залуусын дунд хуурамч мэдээллийн эмзэг байдал, хуурамч мэдээллийн тархалт болон хуурамч мэдээлээс үр дүнтэй сэргийлэх, сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэхэд бүлгийн мэдээлэл харилцааны онцлогийг харгалзан үзэх нь чухал юм.

Иймд залуучуудын дундах бүлгийн мэдээллийн орон зайн зураглалыг гаргах, тэдгээрт оролцож буй талуудыг тодорхойлох улмаар тэдгээрийн онцлогт тулгуурлан сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх боломжийг эрэлхийлэх зорилгоор залуучуудын бүлгийн мэдээллийн орон зайн шинжилгээг гүйцэтгэв.

Дүрс 9. Бүлгийн мэдээллийн орон зай болон мэдээллийн түвшний матрикс



Залуучуудын хувьд хамгийн түгээмэл мэдээллийн орон зай нь сургууль, гэр, ажил нь байна. Дэлгүүр, кофе шоп, спорт заал, клуб зэрэг нь залуучууд харьцангуй тогтмол зорчдог газрууд боловч идэвхтэй мэдээллийн орон зай биш байна. Харин мэдээллийн харьцангуй идэвхтэй орон зай болох албан хурал, уулзалт, хэлэлцүүлэг, албан газар, сургалтын төв зэрэгт залуучуудын зорчих идэвх сул байдаг байна.

Дүрс 10. Тогтмол харилцдаг хүмүүс, %



Дүрс 11. Мэдээлэл дамжуулагчид, %



Залуучууд дээрх мэдээллийн орон зайд голчлон найз нөхөд, гэр бүл, хамтран ажиллагсад болон суралцагсад гэсэн ойрын хүрээллийн оролцогчидтойгоо л түлхүү харилцдаг ба эдгээр хүрээллийн хүмүүс нь нийгмийн байр суурь, итгэл үнэмшлийн хувьд өөртэй нь ижил байр суурьтай (10-аас 7,53 оноогоор) байдаг гэж үзэж байна. Мөн залуус мэдээллийг голчлон (89,5%) ойрын хүрээллийн хүмүүсээсээ авч байна. Залуусын дунд хамгийн идэвхтэй мэдээлэл дамжуулагч нь найз нөхөд нь байгаа бол түүний дараагаар гэр бүл нь орж байна.

Залуучуудын 55.5% нь хүрээлэл дэх хүмүүс нь тухайн оролцогчийг асуугаагүй байхад мэдээ, мэдээлэл тогтмол хуваалцдаг гэж хариулав. Идэвхтэй мэдээлэл дамжуулах байдал нь гэр бүл (58.4%), найз нөхдийн (57.3%) зүгээс ялимгүй өндөр байна. Залуучууд нийгмийн хүрээллээсээ олж авсан мэдээллийн ач холбогдлыг харьцангуй эергээр (6.96) үнэлж байна.

Мэдээллийн зан үйлийн хувьд залуучуудын 34,8% нь мэдээллийг бие даан идэвхтэй эрэлхийлдэг бол 31,1% нь мэдээлэл эрэлхийлэх идэвхтэй зан үйлгүй бөгөөд ойрын хүрээллээрээ дамжуулан мэдээлэл олж авч байна. Мэдээлэл идэвхтэй эрэлхийлэгчид нь өөрийн хүрээллээс авсан мэдээллийн ач холбогдлыг илүү өндрөөр үнэлж байна.

Гэвч мэдээллийн эх сурвалжийн хувьд залуучуудын 81% нь сошиал медиагаас, 73,8% нь өөрийн ойрын хүрээллээс, 45.1% нь уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээс олж авдаг гэж хариулсан. Цахим орчинд ч мөн бүлгийн мэдээлэл дамжуулах эрчим өндөр залуусын 49% нь цахим орчин ойрын хүрээллийн хүмүүс мэдээллийг тогтмол хуваалцдаг гэж хариулжээ. Түүнчлэн цахим орчин дах бүлэгт ч мөн найз нөхөд (37.3%), гэр бүл (18.3%), ажлын (10.3%) болон ангийн хамт олон (13.3%) гэх мэт ойрын хүрээллийн оролцогчид илүү идэвхтэй байна. Эдгээрээс гадна хобби, сонирхлын бүлгийн харилцаа мөн харьцангуй өндөр (16%) байна.

Түүнчлэн залуучууд өөрсдөө мөн цахим орчинд харьцангуй идэвхтэй (6.64) мэдээлэл дамжуулагчид болж байна. Залуусын 38,8% нь цахим орчинд мэдээллийг тогтмол бусадтай хуваалцдаг байна.

Бүлгийн мэдээллийн зан үйлийн шинж чанарын хувьд залуучуудын 35,2% мэдээллийн идэвхгүй зан үйлтэй бүлэг байна. Тэд бүлгээс мэдээлэл илүү авч байгаа (3,6) ч бүлгийн гишүүдийн ижилсэл өндөртэй (8,59), сошиал медиаг мэдээллийн голлох эх сурвалжаа болгодог (4,63) ч өөрсдөө мэдээлэл идэвхтэй эрэлхийлдэггүй залуус байна. Эдгээр залуусын хувьд мэдээллийн "хайрцагт" орох эрсдэл илүү өндөр байх магадлалтай.

Залуучуудын 32.9% нь мэдээлэл идэвхтэй эрэлхийлэгч залуус байна. Тэд цахим орчинд идэвхтэй (8,15), бүлгийн мэдээллийн орон зайд мэдээлэл харьцангуй тогтмол олж авч байгаа (3,38), цахим орчноос мэдээлэл түлхүү (4.30) авдаг залуучууд байна.

Харин залуусын 31.9% нь бүлгийн мэдээллийн зан үйлийн хувьд “тусгаарлагдсан” залуус байна. Тэд бүлгийн мэдээллийн орон зайгаас мэдээлэл бага авдаг (2,71), цахим орчин дахь идэвх бага (5,56), сошиал медиагаас мэдээлэл бага (3,85) авч байна.

Бүлгийн мэдээллийн орон зайн хэв маяг нь нас, байршил, боловсрол, орлого, гэр бүлийн байдал, ажил эрхлэлт зэрэг нийгэм-хүн амзүйн үзүүлэлттэй уялдаагүй байна. Цорын ганц ач холбогдолтой ялимгүй ялгаа хүйсийн хувьд илэрсэн бөгөөд ($\chi^2=6.49$, $p=.039$, $V=.128$) залуу эрэгтэйчүүдийн хувьд бүлгийн мэдээллийн зан үйлээс тусгаарлагдсан байдал өндөр (38.3%), залуу эмэгтэйчүүдийн хувьд идэвхгүй хүлээн авагчид (37.3%) илүү өндөр байна. Байршлын хувьд Улаанбаатарт идэвхгүй хүлээн авагч (43.0%), Хөвсгөлд тусгаарлагдсан бүлэг (41.7%) харьцангуй давамгайлах чиг хандлага байгаа ч энэ үр дүн нь статистик ач холбогдолгүй байв.

Залуусын бүлгийн мэдээллийн орон зайн ангилал (идэвхгүй хүлээн авагч, идэвхтэй эрэлхийлэгч, тусгаарлагдсан хэрэглэгч) нь судалгааны үндсэн хэмжилтүүдтэй хэрхэн уялдаж байгааг нэг хүчин зүйлт дисперсийн шинжилгээ (ANOVA)-ээр тодорхойлов.

Хүснэгт 15. Бүлгийн мэдээллийн зан үйлийн хэв маяг болон DVI, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн хамаарал

Хувьсагч	Идэвхгүй хүлээн авагч бүлэг Дундаж	Идэвхтэй эрэлхийлэгч бүлэг Дундаж	Тусгаарлагдсан бүлэг Дундаж	F	Нөлөөлөл
Хуурамч мэдээлэлд итгэх	2.87	2.99	2.69	4.82**	бага ($\eta^2=.024$)
Хуурамч мэдээллийг түгээх	2.22	2.32	2.01	3.67*	бага ($\eta^2=.018$)
Үнэн мэдээллийг таних	2.70	2.64	2.77	0.91	байхгүй
Хуурамч мэдээллийг эмзэг байдал	2.60	2.65	2.49	5.00**	бага ($\eta^2=.025$)
Хэвлэл мэдээлэл Мэдээллийн боловсрол	3.94	4.08	3.62	18.99***	дунд ($\eta^2=.087$)
Танин мэдэхүй	48.5	49.0	46.9	2.34	байхгүй
Итгэл шүүлт	48.2	47.7	45.9	1.81	байхгүй
Сэтгэл хөдлөл	51.2	51.0	48.2	1.92	байхгүй

Бүлгийн мэдээллийн зан үйлийн хэв маяг нь залуусын танин мэдэхүй, сэтгэл зүйн хүчин зүйлстэй хамааралгүй байгаа ч хуурамч мэдээллийн эмзэг байдалтай бага зэргийн уялдаатай байна. Тухайлбал мэдээлэл идэвхтэй эрэлхийлэх хэв маягтай залуус хуурамч мэдээллийн эмзэг байдал хамгийн өндөр харин бүлгийн мэдээллийн зан үйлээс тусгаарлагдсан залуусын хувьд хуурамч мэдээллийн эмзэг байдал хамгийн бага байх хандлага ажиглагдав. Энэ нь залуусын мэдээлэлд өртөх байдал нь хуурамч мэдээллийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх боломжтойг илэрхийлж байж болно. Дээрх бүлгүүдийн мэдээллийн эмзэг байдлын энэ ялгаа нь хуурамч мэдээлэлд итгэх байдал болон хуурамч мэдээллийг түгээх хандлагаар тодорхойлогдож байна. Тухайлбал мэдээлэл идэвхтэй эрэлхийлэгч залуус нь хуурамч мэдээлэлд илүү итгэх хандлагатай төдийгүй хуурамч мэдээллийг түгээх хандлага бусад бүлгээс ялимгүй илүү байна.

Гэвч дээрх үр дүнг тайлбарлахдаа бүлгийн мэдээллийн зан үйлийн хэв маяг нь мэдээллийн эмзэг байдалд нөлөөлж байна гэж үзэхээс илүүтэй ялгаатай хэв маяг бүхий залуусын мэдээллийн эмзэг байдлын онцлог шинжүүд нь ялгаатай байна гэж ойлгох нь зүйтэй. Иймд бүлгийн мэдээллийн орон зай, мэдээллийн зан үйлийн онцлогийг харгалзан хуурамч мэдээллийг сөрөн тэсвэрлэх чадавхыг зөвхөн хувь хүний түвшинд бус бүлгийн түвшинд авч үзэн хариу арга хэмжээ авах зохих шаардлага байгаа нь ажиглагдаж байна.

4. Хэлэлцүүлэг

Судалгааны үр дүнгээс харахад залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын дундаж индекс 2.58 буюу харьцангуй бага байна. Гэвч энэхүү үзүүлэлтийг эмзэг байдал бага гэж шууд дүгнэх нь учир дутагдалтай юм. Үр дүнг нарийвчлан авч үзэхэд хуурамч мэдээллийг таних байдал (2.85) харьцангуй сайн байгаа бол үнэн мэдээлэлд итгэх байдал (2.70) мэдэгдэхүйц доогуур байна. Залуучуудын 51.5 хувь нь бүх эсвэл зарим үнэн мэдээлэлд итгэхгүй байгаа нь зөвхөн хуурамч мэдээллийг ялгах чадварт бус, мэдээлэлд итгэх ерөнхий хандлага буурч байгааг илэрхийлж болзошгүй юм. Цаашдын судалгаа, үнэлгээнд ХМЭБ болон мэдээлэлд эргэлзэх, үл итгэх хандлагыг нарийн тодорхойлж, хоорондын уялдаа, нөлөөг нарийвчлан үнэлэх шаардлагатай. Мэдээлэлд эргэлзэх эсвэл үл итгэх хандлага нь хуурамч мэдээллийн үр дагаврыг саармагжуулж болох ч мэдээллийн баттай эх сурвалж, үнэн мэдээлэлд ч эргэлзэх, улмаар үр дүнтэй нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хумих, ардчиллын үйл явцад бэрхшээл дагуулах эрсдэл өндөр юм.

Ийнхүү залуучуудын дунд ажиглагдаж байгаа зүйл нь мэдээллийн боловсрол дээшилснийг бус, харин мэдээлэлд бүхэлд нь эргэлзэх хандлага нэмэгдэж байгааг харуулж байх магадлалтай. Энэ нь өөрөө хуурамч мэдээллийн нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөний нэг юм. Энэ ялгааг ойлгох нь бодлогын хувьд маш чухал. Иймд зорилтот арга хэмжээ зөвхөн хуурамч мэдээллийг олж таних чадварыг хөгжүүлэхэд бус, үнэн мэдээлэлд итгэх орчин болон итгэлцлийн суурийг бэхжүүлэхэд давхар чиглэгдэх ёстой. Мэдлэгийн хандлагаас иргэний итгэлцлийн хандлага руу шилжих энэхүү алхам нь цаашдын интервенцийн зорилгод чухал байр суурь эзлэх учиртай.

Хүснэгт 16. DVI болон суурь хүчин зүйлсийн хамаарал, корреляцийн шинжилгээ дүн

	DVI	Худал мэдээнд итгэх	Худал мэдээг хуваалцах	Үнэн мэдээнд итгэх	Үл итгэх хандлага	Эргэлзэх хандлага	Танин мэдэхүй	Итгэл үнэмшил	Сэтгэл хөдлөл
Худал мэдээнд итгэх	.727**								
Худал мэдээг хуваалцах	.865**	.666**							
Үнэн мэдээнд итгэх	-.170**	-.653**	-.494**						
Үл итгэх хандлага	-.460**	-.845**	-.558**	.800**					
Эргэлзэх хандлага	-.498**	-.912**	-.639**	.906**	.905**				
Танин мэдэхүй	.403**	.362**	.302**	-.082	-.237**	-.246**			
Итгэл үнэмшил	.395**	.513**	.465**	-.452**	-.460**	-.531**	.298**		
Сэтгэл хөдлөл	.369**	.381**	.422**	-.305**	-.346**	-.378**	.231**	.434**	
Нас	-.017	-.098	.001	.072	.068	.094	-.096	-.143**	-.057
Боловсрол	-.074	-.192**	-.119*	.223**	.215**	.228**	-.142**	-.224**	-.138**
Орлого	-.054	-.003	-.014	-.067	-.031	-.035	-.076	.040	-.008

** Статистик ач холбогдлын зэрэг < 0,01 *Статистик ач холбогдлын зэрэг < 0,05

Судалгааны хамгийн анхааралтай үзэх үр дүнгүүдийн нэг бол залуучуудын мэдээллийн боловсролын өөрийн үнэлгээ (дундаж 3.88/5.00) ба хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлын индексийн хооронд

ямар ч статистикийн хамаарал илрээгүй явдал юм ($F(1, 398) = 0.152, p = .697, R^2 = .000$). Мэдээлэл олж авах, мэдээллийг үнэлэх, мэдээлэл бүтээж хуваалцах гэсэн гурван дэд бүрэлдэхүүн тус бүр ч эмзэг байдалтай ач холбогдолтой хамаарал үзүүлсэнгүй. Энэ үр дүн нь мэдээллийн боловсрол нь хуурамч мэдээлэлтэй тэмцэх үр дүнтэй хүчин зүйл гэж үзэх олон улсын уламжлалтай зөрчилдөж байна. Гэвч үүнийг илүү нарийн тайлбарлавал нэгд судалгаанд оролцогчид өөрсдийн мэдлэг, ур чадварыг бодитоор үнэлж чадаж байгаа эсэх, хоёрт мэдлэг ойлголт нь дадал болон төлөвшиж байгаа эсэх гэсэн хоёр өөр түвшинд анхааран цаашид судалбал зохино. Энэ утгаараа хэвлэл мэдээллийн боловсролын хөтөлбөрийн үр нөлөөг зөвхөн мэдлэгийг нэмэгдүүлэхэд бус, харин зан үйлийн дадал бүрдүүлэх зорилгод чиглүүлэх шаардлагатай байна.

Судалгааны өөр нэг чухал олдвор бол хүн ам зүйн хүчин зүйлс, тодруулбал нас, хүйс, боловсрол, орлого, байршил — хамтдаа эмзэг байдлын ялгааны зөвхөн 4.8 хувийг тайлбарлаж байгаа явдал юм ($F(9, 390) = 2.18, p = .023, R^2 = .048$). Харин гурван сэтгэл зүйн хүчин зүйл, танин мэдэхүй, итгэл шүүлт, сэтгэл хөдлөл — хамтдаа 27.9 хувийг тайлбарлаж байна. Энэхүү үр дүн нь эмзэг байдал нь хэн байх вэ гэдгээс биш, харин хэрхэн мэдээлэл боловсруулдаг вэ гэдгээс хамаарч байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Боловсролын түвшин дангаараа харьцангуй тогтвортой нөлөө үзүүлж байгаа ($\beta = -0.179, p = .004$) нь боловсрол нь мэдээллийг аналитик байдлаар боловсруулах дадал бүрдүүлэхэд тодорхой үүрэгтэй болохыг харуулж байна. Энэ утгаараа, залуучуудын хувьд сургалт, нөлөөллийн ажил, чадавх бэхжүүлэх арга хэмжээ нь хамгийн үр дүнтэй суурь арга хэмжээ байх боломжтойг харуулж байна. Гагцхүү сургалтын агуулга, хэлбэр нь залуучуудын танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөл зэрэг мэдээлэл боловсруулах механизмын эмзэг байдалд чиглэхээс гадна бүлгийн мэдээллийн зан үйлийн онцлогт чиглэсэн байх шаардлагатай байна. Нөгөө талаас, хуурамч мэдээлэлд эмзэг бүлгийг тодорхойлохдоо хүн ам зүйн хэв шинжид тулгуурлах нь өрөөсгөл хандлага болох ба үр дүн муу байх магадлалтайг харж болно. Энэ утгаараа хуурамч мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээг тодорхой хүн ам зүйн бүлгүүд рүү чиглүүлэхийн оронд мэдээлэл боловсруулах танин мэдэхүйн хэв маягт нөлөөлөх нийтлэг арга хэмжээ илүү өргөн хүрээтэй, үр дүнтэй байх магадлалтай.

Шинжилгээний үр дүн залуучуудын хуурамч мэдээлэлд өртөмтгий байдал нэг биш гурван бие даасан механизмаар бүрэлдэж байгааг нотолж байна: танин мэдэхүй ($\beta = 0.290$), итгэл үнэмшил ($\beta = 0.218$), сэтгэл хөдлөл ($\beta = 0.207$). Гурван хүчин зүйл тус бүр статистикийн ач холбогдолтой байхын зэрэгцээ хамтдаа хуурамч мэдээлэлд өртөмтгий байдлын гол бүтцийг бүрдүүлж байна. Эдгээр гурван хүчин зүйл нь ХМЭБ-ыг тодорхойлохоос гадна өөр хоорондоо статистик ач холбогдолтой шууд хамааралтай байгааг харж болно. Энэ нь эдгээр хүчин зүйлсийн аль нэг нь эмзэг байх нь нөгөө хүчин зүйлсээ өдөөх улмаар, ХМЭБ-д нийлмэл нөлөө үзүүлэх хандлага байгааг илэрхийлнэ. Иймд зөвхөн танин мэдэхүйн чадавхыг бэхжүүлснээр ХМЭБ-г бууруулах боломжгүй бөгөөд итгэл үнэмшилд суурилсан шүүлт болон сэтгэл хөдлөлийн хүчин зүйл өндөр бол танин мэдэхүйн чадавхын эерэг нөлөөг саармагжуулах эрсдэл байна гэж үзнэ.

Түүнчлэн эдгээр гурван хүчин зүйл нь ХМЭБ-ын дэд үзүүлэлтүүдтэй статистик ач холбогдол өндөртэй хамаарал үзүүлж байна. Эдгээр хүчин зүйлсийн эмзэг байдал буурснаар хуурамч мэдээлэлд итгэх, хуурамч мэдээлэл хуваалцах байдал буурч, харин үнэн мэдээнд итгэх, мэдээлэлд эргэлзэх, үл итгэх хандлагууд нэмэгдэж байна. Эдгээрээс танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлийн хүчин зүйлс болоод үнэн мэдээлэлд итгэх итгэлийн хамаарлын түвшин хамгийн бага байна. Иймд нөлөөллийн ажил нь хуурамч мэдээлэлд итгэх байдлыг бууруулж болох ч мэдээллийн найдвартай эх сурвалжийг тодорхойлох, түүнд итгэх байдлыг нэмэгдүүлж чадахгүй бөгөөд ХММБ-ийг хамтад нь олгох зайлшгүй шаардлагатай юм. Ингэснээр хуурамч мэдээлэлд итгэх байдлыг бууруулахын зэрэгцээ найдвартай мэдээллийн эх сурвалж, мэдээллийг таних, ашиглах дадал суулгаж, ХМЭБ-ыг дорвитой бууруулах боломжтой нь харагдаж байна.

Түүнчлэн нас болон байршлаар авч үзэхэд залуусын хуурамч мэдээллийн эмзэг байдлын түвшинд үзүүлэх танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлийн хүчин зүйлсийн нөлөө ялгаатай илэрч байгаа. Энэ нь нэгдсэн нэг хөтөлбөрийг бүх залуучуудад нийтлэг хэрэглэх боломжгүйг илтгэж байна. Үр дүнтэй интервенц нь тухайн бүлгийн эмзэг байдлын зонхилох механизмд чиглэсэн байх ёстой. Тухайлбал хотод сэтгэл хөдлөлөө зохицуулах чадварт чиглэсэн, харин хөдөөд суурь аналитик чадвар болон залруулгыг хүлээн авах орчин бүрдүүлэх арга хэмжээ илүү нөлөөтэй байх боломжтой.

Хувь хүний сэтгэл зүйн хүчин зүйлсийн зэрэгцээ залуучуудын мэдээлэл хүлээн авдаг орчны бүтэц нь эмзэг байдалд тусдаа, чухал нөлөө үзүүлдгийг судалгааны үр дүн харуулж байна. Залуучуудын 89.5 хувь нь мэдээллийг ойрын хүрээллийнхнээсээ авдаг бөгөөд тухайн хүрээлэл нь байр суурь, итгэл үнэмшлийн хувьд хоорондоо нэгтэй (7.53/10.00) байдаг гэж үздэг. Залуучуудын 55.5 хувь нь ойрын хүрээллийн хүмүүс нь асуугаагүй байхад мэдээлэл, мэдээ тогтмол хуваалцдаг гэж хариулжээ.

Бүлгийн мэдээллийн орон зай, мэдээлэл дамжуулагч, мэдээллийн зан үйлийн хэв шинжүүдээр нь авч үзвэл хуурамч мэдээллийн эмзэг байдалд хязгаарлагдмал нөлөөтэй байгааг шинжилгээ үр дүн харуулсан. Энэ нь бүлгийн бүтэц, зан үйл нь эмзэг байдлыг бүтцийн шинжтэй болгодог ба мэдээллийн эмзэг байдал нь хувь хүний чадавх, зан үйлээс гадна мэдээллийн экосистемийн асуудал гэж авч үзэх ёстойг ёстойг илтгэж байна. Өөрөөр хэлбэл хувь хүний танин мэдэхүй, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлийн дадал, чадавх сайн байсан ч бүлгийн эмзэг байдал өндөр бол бүлгийн мэдээллийн зан үйлээр дамжин хуурамч мэдээлэлд дам өртөх эрсдэл тодорхой түвшинд байгаагаас гадна бүлгийн мэдээллийн зан үйл нь хуурамч мэдээллийг нөлөөг нэмэгдүүлэх боломжтой байна. Иймд хуурамч мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээг зөвхөн хувь хүний танин мэдэхүй, чадварт чиглүүлэхийн зэрэгцээ мэдээлэл дамжих нийгмийн сувгийг, бүлгийн бүтэц, орон зай, түүний нөлөөг тооцон үзэх шаардлагатай. Үүний тулд бүлгийн мэдээллийн орон зайн нарийвчилсан судалгааг цаашид гүйцэтгэвэл зохино.

Зөвлөмж

Судалгааны үр дүн нь зөвхөн залуучуудын хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдал буюу DVI, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлоход хамаарах бөгөөд нийгмийн нийтлэг, эсвэл бусад бүлэгт чиглэсэн аливаа арга хэмжээ шууд ашиглах нь зохисгүй юм. Түүнчлэн, судалгааны үр дүнд суурилан гаргаж буй доорх зөвлөмжүүдийг ч мөн залуучуудад чиглэсэн аливаа арга хэмжээнд голчлон авч үзэн ашиглах нь зүйтэй.

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах зөвлөмжүүдийг гаргав.

1.Цаашдын нарийвчилсан судалгаа, шинжилгээ:

- DVI-ыг хэмжих аргачлалыг цаашид нарийвчлан боловсруулж, мэдээлэлд эргэлзэх нийтлэг хандлага, мэдээлэлд үл итгэх хандлага зэргийг цаашид үндэсний түвшинд хэмжих шаардлагатай. Ингэхдээ давтан судалгааны хэлбэрээр гүйцэтгэж, хуурамч мэдээллийн нөлөөг тодорхойлох нь цаашдын хариу арга хэмжээнд чухал нотолгоог бүрдүүлнэ.
- Түүнчлэн бүлгийн мэдээллийн орон зай, бүлгийн мэдээллийн зан үйлийн нарийвчилсан судалгааг гүйцэтгэж, бүлгийн бүтэц, зан үйл хуурамч мэдээлэлд өртөмтгий эсвэл тэсвэртэй байхад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох нь чухал юм. Учир нь DVI нь хувь хүний онцлогоос гадна бүлгийн бүтцийн онцлогоос хамаарч байгааг судалгааны үр дүн харуулсан. Иймд хуурамч мэдээллийн бүлгийн түвшинд үзүүлж буй бүтцийн механизмыг тодорхойлох нь DVI-ыг дэмжиж буй олон нийтийн бүтцийн нөлөөг тодорхойлоход чухал юм.
- Түүнчлэн ХММБ, түүний үр нөлөөний үнэлгээг тусгайлан хийж, ХММБ-ыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын үр нөлөөг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай. Боловсролын түвшин DVI-ын бүрэлдэхүүн үзүүлэлтүүд, түүнд нөлөөлж буй хувь хүний хүчин мэдээллийн зан үйлийн хүчин зүйлстэй хүчтэй хамааралтай байгаа нь мэдлэг, хандлага, чадавх бэхжүүлэх ажлууд нь үр нөлөөтэй байж болохыг харуулж байна. Энэ утгаараа, иргэдийн түүн дотроо залуучуудын мэдээллийн зан үйл, чадавхыг бэхжүүлэх нь хуурамч мэдээлэлтэй тэмцэх ур хугацааны хамгийн тогтвортой үр дүнтэй арга гэж үзэж болохоор байна. Гэвч ХММБ-ын өнөөгийн түвшин, түүнд чиглэсэн нөлөөллийн ажлын үр нөлөө, ХММБ-ыг дээшлүүлэх нөлөөллийн ажлууд нь ямар механизмаар хэрхэн DVI-д нөлөөлж буй нарийвчлан судалснаар цаашдын хариу арга хэмжээний үр дүнг сайжруулах боломж бүрдэнэ.

2.Хуурамч мэдээллийн тогтолцооны эсрэг хариу арга хэмжээ.

- Залуучуудын эх сурвалжид шүүлтүүргүй итгэх байдал 50.05 оноотой гарсан бөгөөд энэ нь DVI-ын үзүүлэлттэй шууд хамааралтай байгаагаас үзвэл залуучуудын дунд найдвартай, хариуцлагатай мэдээллийн эх сурвалжийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Ингэснээр DVI-д тодорхой нөлөө үзүүлж болох нь судалгаагаар нотлогдож байна. Үүний тулд хариуцлагатай хэвлэл мэдээллийг хөгжүүлэх, шошгожуулах, түүнийг олон нийтэд таниулах, хүргэх шаардлагатай.
- Мөн залуучуудын дунд олон дахин давтагдах мэдээллийг үнэн мэт хүлээн авах хандлага 49,9 оноотой үнэлэгдсэн бөгөөд DVI-д мөн адил нөлөөлж байна. Хуурамч мэдээллийг олон дахин, өндөр давтамжтай түгээхэд олон хуурамч хаяг, тролл сүлжээний оролцож байгааг зураглалын судалгаагаар тодорхойлсон. Түүнчлэн бүлгийг даган дуурайх хандлага залуучуудын дунд өндөр буюу 54 оноотой бөгөөд DVI-д багагүй нөлөөтэй байна. Хуурамч хаяг, тролл сүлжээнүүд нь хуурамч мэдээллийг олон дэмжиж байгаа мэт сэтгэгдлийг төрүүлэх зорилгоор, мөн сошиал медиа платформын алгоритмыг ашиглан мэдээллийг улам түгээх нөхцөлд хүргэдэг. Иймд хуурамч хаягууд болон тролл сүлжээтэй дорвитой тэмцсэнээр залуусын итгэл үнэмшлийн зан үйлийн механизмаас үүсэж DVI-ыг саармагжуулах боломжтой байна. Үүний тулд сошиал

медиа платформуудтай хамтран нээлттэй, хариуцлагатайгаар хамтран ажиллах, тролл сүлжээ зэрэг зохион байгуулалттай бүлгүүдийн эсрэг хариуцлага, арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

- Залуучуудын бүлгийн мэдээллийн орон зайд сошиал медиа, сошиал медиа дах бүлгүүдийн нөлөө өндөр байна. Залуучуудын 81% нь сошиал медиагаас мэдээлэл авч байна. Платформ дизайн нь хуваалцах зан үйлд шууд нөлөөлдөг болохыг олон улсын туршилтууд нотолсон. Жишээлбэл, Twitter-ийн "Are you sure?" санамж мэдээний холбоосыг хуваалцах байдлыг 38%-аар бууруулсан байдаг. Иймд эх сурвалжгүй мэдээллийг хуваалцахад баталгаажуулж асуух, community standard-аар дамжуулан influencer, пэйж хуудаснууд зэргийг эх сурвалжаа дурдах, хуурамч мэдээлэл түгээхгүй байхад чиглэсэн хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг платформуудтай хамтран хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэх зэрэг идэвхтэй арга хэмжээ авах нь үр дүнтэй байж болох юм.
- Залруулгыг хүлээн авахаас татгалзах хандлага залуусын дунд харьцангуй бага буюу 36,73 оноотой төдийгүй DVI-д багагүй нөлөөтэй байна. Иймд баримт шалгах төвүүдийн үйл ажиллагааг цаашид илүү өргөжүүлэх, баримт шалгалтын үр дүнг олон нийтэд идэвхтэй хүргэх, зарим хуурамч мэдээллийн нарративыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх буюу "pre-bunking" туршлага, тогтолцоог бэхжүүлснээр DVI-г бууруулахад эерэг нөлөөтэй болох нь харагдаж байна. Үүний тулд баримт шалгах төвүүдийг дэмжих, баримт шалгахад мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, баримт шалгахад технологийг үр дүнтэй нэвтрүүлэх зэрэг алхмуудыг цаашид цогцоор нь авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

3.Залуучуудын хуурамч мэдээлэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээ.

- Залуучуудын хувь хүний танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, итгэл үнэмшлийн дадал хандлагад чиглэсэн ХММБ-ын хүртээмжтэй, онцлогт нийцсэн сургалт, нөлөөллийн ажлыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатайг судалгааны үр дүн харууллаа. Үүний зэрэгцээ залуучуудын дадал, зан үйлд эергээр нөлөөлөх зорилгоор дараах арга хэмжээнүүд мөн хэрэгжүүлж болох юм.
- Залуучуудын дунд сэтгэл хөдлөлд хөтлөгдөх хандлага, түүн дотроо айдас түгшүүр гэх мэт хүчтэй сэтгэл хөдлөлд автах хандлагатай өндөр буюу 56,24 оноотой байна. Энэ нь залуучуудын DVI-д сөргөөр нөлөөлж байна. Хуурамч мэдээллийн арга техникүүдэд хүчтэй сэтгэл хөдлөлд автуулах, өдөөх зорилготой агуулга багагүй байгааг өмнөх зураглалын судалгаанд тодорхой харуулсан. Иймд эдгээр хуурамч мэдээллийн сөрөг нөлөөг саармагжуулах үүднээс ийм төрлийн мэдээллийг хуваалцах, хариу үйлдэл үзүүлэхийн өмнө багахан хугацаанд зогсож азнах дадал бүрдүүлэх нь үр дүнтэй байдаг. Зан үйлийн туршилт судалгаануудад (Pennyscook et al., 2021) иймэрхүү энгийн аргачлал буруу мэдээллийг хуваалцах зан үйлийг 20–30%-аар бууруулдаг болохыг баталсан.
- Эх сурвалжид итгэх (50,05 оноо), бүлгийг даган дуурайх (54 оноо) хандлага буюу нийгмийн нийцлийн хандлагууд харьцангуй өндөр байгаа нь судалгаагаар ажиглагдсан. Эдгээр хүчин зүйлсийг эергээр ашиглан залуучуудын итгэдэг эх сурвалжууд, түүн дотроо influencer зэрэг оролцогчдоор дамжуулан "азнах дадал", эх сурвалж шалгах, мэдээлэл нягтлах гэх мэт хуурамч мэдээлэлд өртөхөөс сэргийлэх суурь дадлуудыг залуучуудын нийтлэг хандлага, жишиг болгон төлөвшүүлэх нь залуус эдгээр дадлыг өөртөө суулгахад нь илүү үр дүнтэй нөлөө үзүүлж болно.
- Бүлгийн мэдээллийн орон зайгаас тусгаарлагдсан залуус (31,9%) нь анхаарал хандуулах шаардлагатай онцгой бүлэг байна. Хэдийгээр эдгээр залуус нь хуурамч мэдээлэлд бага өртөж байгаа ч ХММБ, мэдээллийн тэсвэртэй зан үйл мөн адил бүрэлдээгүй байна. Иймд, эдгээр залууст чиглэсэн ирээдүйд хуурамч мэдээлэлд өртөхөөс сэргийлэх, эмзэг байдлыг бууруулах үүднээс ХММБ болон мэдээллийн зан үйлийг нь бэхжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг

хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд орон нутгийн мэдээллийн орон зайн гол зангилаа байгууллага болох сургууль, гэр бүл, үе тэнгийн оролцоонд суурилсан тусгайлсан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлбэл үр дүнтэй.

Бүлгийн зан үйлд чиглэсэн арга хэмжээ.

- Залуучуудын бүлгийн мэдээллийн зан үйл нь биет орчинд ч цахим орчинд ч ялгаагүй ойрын хүрээлээр дамжин мэдээлэл хүлээн авах, түгээх загвартай байна. Хуурамч мэдээллийн тархалтыг саармагжуулах, эерэг дадал, хандлагыг түгээхэд бүлгийн мэдээллийн орон зайн зангилаа байгууллага буюу талбаруудад түшиглэн ажиллах нь чухал байна. Тухайлбал залуусын хамгийн их зорчиж мэдээлэл солилцож буй олон нийтийн талбар нь сургууль бөгөөд цахим орчинд ч анги, хамт олны үүрэг оролцоо өндөр байна. Иймд эдгээр талбаруудад идэвхтэй мэдээллийн оролцогчдыг бэлтгэх, тэдний DVI-г бууруулснаар бүлгийн мэдээллийн орон зайгаар дамжин хуурамч мэдээлэл түгэх түвшнийг тодорхой хэмжээнд саармагжуулах боломжтой. Үүний тулд оюутан сурагчдын клуб, танхим, сурагчдын зөвлөл, эцэг эхийн зөвлөл гэх мэт бүтэц, тэдгээрт идэвхтэй нийгмийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Мөн цаашид цахим орчин дахь бүлгийн мэдээллийн орон зай, зан үйл, оролцогчдыг ч мөн нарийвчлан судалснаар залуучуудын мэдээлэл авч буй хамгийн том талбарт хүрч хариу арга хэмжээг төлөвлөхөд чухал үүрэгтэй байна.

Эцэст нь дүгнэхэд залуучуудын DVI нь хүн ам зүйн нийлмэл үзүүлэлт, хувь хүний мэдээллийн зан үйл, бүлгийн мэдээллийн орон зай зэрэг олон түвшний хүчин зүйлсээс эмзэг хамаарч байна. Иймд, хуурамч мэдээллийн эмзэг байдлыг бууруулах арга хэмжээ нь бүх түвшний хүчин зүйл, тэдгээрийн онцлог механизмд чиглэсэн цогц байдлаар хэрэгжиж байж үр дүнд хүрнэ. Түүнчлэн аливаа хариу арга хэмжээг төлөвлөхдөө зорилтот бүлгийн DVI механизмын онцлогт тулгуурлан ялгавартайгаар боловсруулах нь үр дүнг цаашид нэмэгдүүлэх зөв практик болно.

Ашигласан материалын жагсаалт

- Bastick, Z. (2021). Would you notice if fake news changed your behavior? An experiment on the unconscious effects of disinformation. *Computers in Human Behavior, Volume 116*.
<https://doi.org/https://doi.org/10.1016/j.chb.2020.106633>.
- DISA. (2025, January 4). *The Pervasive Threat of Misinformation and Disinformation: Understanding the Psychology Behind the Spread of Falsehoods* [Disinformation Social Media Alliance].
<https://disa.org/the-psychology-of-misinformation-and-disinformation/>
- IRI. (2024). *Public Opinion Survey*.
- IRIM. (2025). *Mapping of Disinformation in Mongolia*.
- Lewandowski, P. (2024). *Psychological mechanisms of disinformation and their impact on social polarization*. 85–104. <https://doi.org/10.14746/ssp.2024.2.5>
- OptimalNMax. (2024). *Цахим орчин дахь хуурамч мэдээллийн тархалт болон нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа*.
- Pennycook, G., & G Rand, D. (2021). The Psychology of Fake News. *Trends in Cognitive Sciences*, 25(5), 388–402.
- Wolters, H., Kasey Stricklin, Neil Carey, & Megan K. McBride. (2021). *The Psychology of (Dis)information: A Primer on Key Psychological Mechanisms*. CNA.
<https://apps.dtic.mil/sti/trecms/pdf/AD1151655.pdf>